



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.04.24, ЛХАГВА ~ №076 (1128)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Д.Цогтбаатар: 19 оронд суух Элчин сайдын томилгоо хүлээгдэж байна

АНУ, БНАСАУ-ын хооронд гурав дахь уулзалт болох ёстой. > 2

Ирэх сараас сургалтын төлбөр нэмэх эсэх нь тодорхой болно

Эрэлттэй мэргэжил сонгоогүйгээс ажилгүйчүүдийн тоо ихэсдэг. > 4

Ажиллаж буй ахмадуудын тоо АНУ-д хоёр дахин өслөө

АНУ-д 65-аас дээш насны ахмадуудын 20 хувь нь ажиллахаас аргагүй нөхцөлд амьдарч байна. > 10

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

> 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

ТАЗ-өөс ЭМДЕГ-ын Тамгын газрын томилгоог хууль бус гэж үзэн, цуцалжээ.
Нийт газар нутгийн 19.8 хувийг тусгай хамгаалалтад авахаар УИХ хэлэлцэж байна.
ГХЯ: Монгол Улсаас Кувейтэд мах нийлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийллээ.
УХүрэлсүх: Үндэсний номын сангийн барилгын ажлыг энэ онд багтаан дуусгах үүрэг өглөө.

ЭДИЙН ЗАСАГ

Ирээдүйн өв санд 255.9 тэрбум төгрөг төвлөрчээ.
ММС өмнөх улиралд 999 мянган тонн угаасан коксжих нүүрс борлуулжээ.
"Бодь даатгал" компани энэ онд багтаан IPO гаргахаар төлөвлөж байна.
Топ 20 индекс 0.16 хувиар буурч, 19,836.03 нэгжид хүрлээ.



НИЙГЭМ

Дарханы замыг түр хаахын тулд газар чөлөөлөлт, туслах зам барих ажлыг эхлүүлээ.
Утааны тортогжилт хэтэрсэн таван автобусыг хөдөлгөөнд оролцохыг нь хориглов.
ТЦБ-д осолдсон иргэдийн цогцос солигдсоноос үүдэн гарах зардлыг ШШХ-гээс олгоно.
Нийслэлээс очсон иргэд "Шилийн богд"-д гал алдаж, түймэр тавьсан байна.

ДЭЛХИЙ

Шриланкийн эрх баригчид алан хяллагын талаар мэдээлэл авсан байжээ.
Чехийн Ерөнхийлөгч М.Земан Украины сонгуульд ялсан В.Зеленскийг урсан байна.
АНУ Хезболла бүлэглэлийн мөнгөний талаар мэдээлэлд мөнгөн шагнал амлав.
Мягмар гарагт Оросын Владивосток хотод Хойд Солонгосын онгоц газарджээ.
Лондонд экологийн асуудлаар жагсагчдаас мянга гаруй хүнийг баривчиллаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2019.04.24

7° -4°

ҮҮЛШИНЭ



846580004291128 01128

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ОХУ-ЫН ДАВШИЛТ МОНГОЛ НҮҮРСИЙГ ШАХНА



Аль эртнээс өөрийгөө өрсөлдөөнд бэлдсэн, хүчтэй, амбицтай ОХУ, Хятадын нүүрсний зах зээлд Монголтой өрсөлдөх гэж байна. Гэтэл бид энэ өрсөлдөөнийг урьдчилан таамаглаж, анхаарч үзэх сөхөө ч үгүй явна. ► 12

BBM®

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Иргэдээ хянадаг Хятадын арга монголчуудад зохино

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Өмнөд хөрш БНХАУ иргэдээ оноогоор эрэмбэлэх төлөвлөгөөг өнгөрсөн оноос туршилтаар хэрэгжүүлж буйг Bloomberg мэдээлэв. Нийгмийн кредитийн тогтолцоо нэртэй энэхүү төлөвлөгөөний дагуу иргэдээ хууль дүрэм хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгч, “үгэнд ордоггүй” зарим нөхдөд арга хэмжээ авах юм. Тухайлбал, шүүхийн шийдвэрт захирагдахгүй байгаа том толгойтнууд зээл, орон сууц авах, хүүхдээ хувийн

сургуульд суралцуулах эрхгүй болно. Харин иргэний үүргээ үнэнч шударгаар биелүүлж яваа хүн урамшууллын оноо авах юм. Гэхдээ “хар жагсаалт”-д орсон л бол насан туршидаа ад үзэгдэнэ гэсэн үг биш. Хэрэв тухайн хүн дутагдлаа зассан бол өнөөх эрхүүд нь эргээд сэргэх аж. Тус улс зөвхөн 2018 онд өр зээлээ төлөөгүй иргэдийг агаарын тээврийн 17 сая нислэг, галт тэрэгний таван сая аяллаас саатуулжээ. Даварсан нөхдөд даруулга тооцон тун аятайхан арга байгаа биз.

► 3

ЗГМ: СЭДЭВ

Усны агентлаг байхгүйгээс ус, гол ширгэх хүчин зүйл ундарсаар байна

Г.Билгүүн
ЗГМ

Та бид ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд их хэмжээний усыг тогтмол хэрэглэж байгаа дүн мэдээг дэлхийн усны нөөцийн судалгааны байгууллагаас гаргажээ. Нэг лааз кока кола үйлдвэрлэхэд гурав, нэг кг төмс тарихад 250-500, бие гүйцсэн нэг үхрийг амьдралынх нь турш ундаалахад 5-20 мянга, нэг машин үйлдвэрлэхэд 400 мянга, нэг гулдмай алт боловсруулан гаргахад найман сая литр ус

зарцуулагддаг байх юм. Үүний ард усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр нөөц багасах зовлон дагалдана.

Нэг хүнд ногдох усны жилийн хэрэгцээг 1000 шоо метрээс буурахад тухайн орныг усны ноцтой хомсдолд орсон, 500 шоо метрээс бага бол улс орон оршин тогтнох боломжгүй хэмээн үздэг аж. Харин манай улс энэ ангилалд оролгүй хар зураасны гадна бичигдэж байна. Сайндаа ч биш, хүн ам цөөтэй тулдаа, Хөвсгөл нуурынхаа буянаар нэгээс нь ч гэсэн дутаж.

► 5

Монгол Улсын бизнесийн ертөнцөд тэргүүлж, амжилтаа бататгаж буй шилдгүүдийг "Forbes Mongolia" сэтгүүл шалгаруулна.



2019 оны 5 сарын 3, Шангри-Ла зочид буудал
Улаанбаатар хот, Монгол Улс

АЛТ

1273.98
1.01%

ЗЭС

6476
1.22%

10-ЧИНГИС БОНД

98.700
0.13%

ХУРАЛДАЙ БОНД

110.70
0.12%

ГЭРЭГЭ БОНД

99.330
0.12%

АМ.ДОЛЛАР

2,638.33

ЮАНЬ

392.68

РУБЛЬ

41.36

Улс төр

ЗГМ ТОВЧХОН

» ТОО

42

Мянга. Нийгмийн сүлжээтэй холбоотойгоор гар утасны дугаарыг бүртгэлжүүлэх ажлыг холбогдох үүрэн холбооны компаниудтай хамтран хийж эхэлсэн байна. 2016 онд бүртгэлгүй 650 мянган дугаар иргэдийн гар дээр байсан бол өнөөдрийн байдлаар 42 мянга болж буурсан аж. Ирэх зургадугаар сар гэхэд бүртгэлгүй дугаар гэж байхгүй болгохоор албаныхан ажиллаж байна.

» ҮҮРЭГ

Үндэсний номын сангийн шинэ барилгын ажлыг энэ онд багтаан дуусгахыг Ерөнхий сайд үүрэг болголоо. 2014 онд эхэлсэн Үндэсний номын сангийн шинэ байрны барилгын ажил газрын маргаан, санхүүжилт зэрэг асуудлаас болж хугацаа алдаж өнөөг хүрсэн аж.

ЭШЛЭЛ



-Ер нь ямар ч асуудалд Засгийн газрын гишүүд нь оролцохгүй байна. Ажлын хэсгийн гишүүд л ажилладаг боллоо. Цаашид сайдууд нь Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслүүдийг хэлэлцэх үеэр идэвхтэй оролцож Байнгын хороодын гишүүдийн саналыг тусгадаг байдлаар дараа дараагийн хуулиуддаа анхаармаар байна. Байнгын хорооны гишүүд болгочихдог гэсэн шиг цаас чулуудчихдаг, түүн дээр нь бид ажилладаг. Уг нь хуулиараа Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслүүдийг хэлэлцэх үеэр сайд нар оролцдог байх дэгтэй.

УИХ-ын гишүүн Д.Тэрбишдавга

ЗГМ: ТОДРУУЛГА

Д.Цогтбаатар: 19 оронд суух Элчин сайдын томилгоо хүлээгдэж байна

АНУ, БНАСАУ-ын хооронд гурав дахь уулзалт болох ёстой

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Засгийн газрын ээлжит бус хуралдаанд Монгол Улсаас гадаадын зарим оронд суух Элчин сайдын томилгооны асуудлыг хэлэлцсэн байна. Гадаад харилцааны яамнаас 20 орчим орны Элчин сайдын томилгоотой холбоотой асуудлыг УИХ-ын чуулганд танилцуулахад бэлэн болжээ. Өнгөрсөн онд Казахстан, Польш, Унгар, Египет, Тайланд, Сингапур, Лаос, Кыргыз, Австралид суух Элчин сайд нарын бүрэн эрхийн хугацаа дуусчээ. Түүнчлэн Н.Чимгүүндарь, Б.Хурц, Г.Тэнгэр нарыг Элчин сайдаас татаж, оронд нь шинэ Элчин сайд томилохоор болсон байна. Эдгээр оронд суух Элчин сайдаас гадна шинээр консулын газар нээхээр болсон орнуудыг нийлүүлэн тооцвол 20 орчим орны Элчин сайдын томилгоо хүлээгдэж байна гэсэн үг. Хаврын чуулганы хүрээнд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн томилох нь тодорхой.

Зарим эх сурвалжийн хэлснээр

Гадаад харилцааны яамнаас Ази Номхон далайн орнуудын газрын захирал Э.Сарантогос, Европын газрын захирал М.Цэнгэг, Гэрээ, эрхзүйн газрын захирал А.Төмөр, Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлтийн газрын захирал Ш.Одонбаатар, Хөрш орнуудын газрын захирал Т.Жанабазар, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал В.Энхболд, Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал Н.Анхбаяр, Америк, Ойрх Дорнод, Африкийн газрын захирал Д.Гансүх нарыг гадаадын зарим улсад суух Элчин сайдаар томилохоор ярьсан гэж эх сурвалжууд мэдээлж байгаа юм.

ГХЯ-ны газрын захирлуудын нэр Элчин сайдад яригдаж байна

Элчин сайдуудын томилгоо болон цаг үеийн зарим асуудлаар Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатараас дараах тодруулгыг авлаа.

-Элчин сайдуудын томилгоо Засгийн газрын хуралдаанд орж ирж байна. Хичнээн Элчин сайдын асуудал одоо яригдаж



С.Батсайхан / ЗГМ

байгаа юм бэ?

-19 Элчин сайдыг ээлж

дарааллаар нь буцаан татах, томилох талаар ярьж байна.

ЭМДЕГ-ын Тамгын газрын даргыг хууль бусаар томилсон байжээ

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр сонгон шалгаруулалт, дүгнэлтгүйгээр томилсон гэх гомдол иргэдээс

иржээ. Энэ дагуу Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалт явуулсан байна.

Улмаар уг томилгоо нь хууль зөрчсөн гэж үзсэн байна. Төрийн жинхэнэ албанд, төрийн албаны

сонгон шалгаруулалт, дүгнэлтгүйгээр улс төрийн намын гишүүн хүнийг томилсон гэж тус зөвлөл үзсэн аж.

Иймд Засгийн газрын хэрэг-жүүлэгч агентлаг Эрүүл

мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг Төрийн албаны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн дагуу

чөлөөлсөн байна. Улмаар тухайн албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөх мэдэглэлийг Төрийн албаны зөвлөл хүргүүлжээ. [ЗГМ]

ХАРИЛЦАА

Ойрх Дорнодод мах экспортлох талаар судалж байна

Б.Сэлэнгэ
ЗГМ

Монгол Улс, Кувейт Улсын Гадаад хэргийн яамд хоорондын улс төрийн анхдугаар зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо боллоо.

Өнгөрсөн хугацаанд манай улсад Кувейтын Засгийн газар 78 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 17.5 орчим сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлээд байна. Кувейтын хөнгөлөлттэй

зээлийг манай улс Дархан-Эрдэнэт-Булган-Уньт-Тариа-лангийн чиглэлийн 415 км урт авто замыг барих, Тайширын УЦС-ыг барихад ашигласан бол буцалтгүй тусламжийг Түлэнхийн төвийн барилгыг барих, Монгол-Кувейтийн Судалгааны төвийг байгуулах болон бусад төслийг хэрэгжүүлэхэд ашиглажээ.

Энэ үеэр хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх нөөц бололцоог ашиглах талаар талууд ярьсан байна.

Тухайлбал, манай улс Ойрх Дорнодын орнуудад мах экспортлох боломжийг судлан ажиллаж байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотноо зохион байгуулагдах "Ойрх Дорнодын бус нутагт Монголоос мах экспортлох" асуудлаарх бизнесийн уулзалтад Кувейтын тал холбогдох төлөөлөгчдийг ирүүлэх талаар ажиллана гэдгээ энэ үеэр мэдэгдсэн юм. Кувейт Улс нь махны хэрэгцээнийхээ 90 гаруй хувийг гаднаас импортлодог аж. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

Нийт газар нутгийн 19.8 хувийг тусгай хамгаалалтад авна гэв

Б.Энх
ЗГМ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас есөн аймгийн 22 газрыг улсын тусгай хамгаалалтад нэмж авах төслийг боловсруулсан. Эдгээр газар нь нийт 3.4 сая га талбайг хамарч байгаа аж. Ингэснээр байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрх, түүх, соёлын дурсгалууд болон 350 орчим зүйлийн ховор амьтан, ургамал, гол мөрний урсац бүрэлдэх эхийг 3.7 хувиар, ойн сан бүхий газрын 3.2 хувиар хамгаална гэсэн судалгааны дүн гарчээ.

Мөн дээрх газрыг оруулаад

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 19.8 хувь нь улсын тусгай хамгаалалттай болох юм.

Өнөөдрийн байдлаар тусгай хамгаалалттай газар нутгуудад нийт 365 байгаль хамгаалагч ажиллаж байна. Гэвч 80 байгаль хамгаалагчийн орон тоо дутуу аж. 2018 оны судалгаанаас харахад зөрчлийн илрүүлэлт болон зөрчил арилгах хувь өнгөрсөн жилүүдээс 20 хувиар өссөн гэдэг мэдээллийг салбарын яамнаас өгсөн юм. Цаашид нэмж авсан тусгай хамгаалалттай газруудыг харж хамгаалах байгаль хамгаалагчийн орон тоо, төсвийг баталж өгөх шаардлагатайг ч албаныхан хэлсэн юм. [ЗГМ]

ХУУЛИЙН ТӨСӨЛ

Facebook-т регистрийн дугаараар нэвтэрдэг болно

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Үүнд нийгмийн сүлжээнд нэрээ нуусан хаягнаас бусдын нэрээр орохыг болиулах, хориглох арга хэмжээ авах зорилгоор хэрэглэгчийг регистрийн дугаараар нь бүртгэх, зах зээлд давамгайл хуулийн этгээд хамаарал бүхий этгээдэд хөнгөлөлттэй нөхцөлийг олгож, өрсөлдөөний тэгш бус байдал үүсгэж байгааг хязгаарлах зохицуулалтыг төсөлд тусгажээ.

Ажлын хэсгийн гишүүд Facebook компанигай хамтран ажиллахаар хэд хэдэн удаагийн уулзалт хийж, тодорхой асуудлууд дээр тохирсон байна.

Олон нийтийн сүлжээгээр буюу фэйсбүүкээр бусдын эрхэнд халдсан иргэний шинжтэй зөрчлийн үйлдлийг илрүүлэх, хаах бол Харилцаа холбооны зохицуулах газартай, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэх бол цагдаагийн байгууллагатай, үндэсний аюулгүй байдалтай холбоотой бол тагнуулын байгууллагатай хамтран ажиллахаар тохиролцжээ.

Харин тус компанийн зүгээс манай улсыг хууль эрх зүйн орчноо боловсронгуй болгох шаардлага тавьсан бөгөөд тэдгээр асуудлыг Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд нарийвчлан тусгаж авна. [ЗГМ]

[ЗГМ СӨНИН]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Батарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар, 1024
Утас: 70103131,
Факс: 70106006

ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Э.Батцэцэг



8465000429112 001128



Японы хөрөнгө оруулалттай Инвэскор Санхүүгийн байгууллага нь байгуулагдсан цагаасаа эхлэн тогтвортой өсөлттэй байж, Монгол улсын санхүүгийн зах зээлд байр сууриа батжуулан, Банк бус санхүүгийн салбарт тэргүүлэгч байгууллага болон өсөн дэвжж байна.

Бид Харилцагч төвтэй үйлчилгээг дээдэлж, тэдэнд зөв, харууцлагатай санхүүгийн мэдээг, төлөвлөлийг олгох чиглэлийг эрхэм болгон үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ олон улсад танигдсан, орчин үеийн технологийн дэвшилийг нэвтрүүлэгч байхыг зорин ажилладаг.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 7 салбартай, тэдгээрээр дамжуулан харилцагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түргэн шуурхай санхүүгийн үйлчилгээг үзүүлж, санхүү, бизнесийн зөвлөгөө өгч байна.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

- Санхүү, эдийн засгийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Санхүүгийн шинжлэлтээр 2-оос дээш жил ажилласан туршлагатай;
- Хариуцлагатай, ачаалал даах чадвартай;
- Англи хэлний дундаас дээш мэдлэгтэй;
- Компьютерийн хэрэглээний програмуудыг бүрэн эзэмшсэн;
- Тогтвор суурьшилтай ажиллах сонирхолтой;
- Үнэт цаасны компанид ажиллаж байсан туршлагатай бол дөвүү тал болно.


Та өөрийн анкетаа info@invescore.mn хаягаар илгээж үү. Зөвлөн анкетийн сонгон шалгаруулалтаанд тэнцсэн кандидат руу хэлбэр барих байна.

ХОЛБОО БАРИХ

Утас: 7709-0077, 9004-9938
Хаяг: 13 даяар - Төвн Тауэр 1, Сөүлийн гудамж 10/1,
2 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

Нийтлэлчийн булан

Хулгайч нараас болж монголчуудын нэр олон улсад унасаар байна



ЗГМ

байна лээ. Тухайлбал, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын визийг хуурамчаар үйлдэн гадаад паспорт дээрээ дарах, нийгмийн даатгалын лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, татварын тодорхойлолт, гэрлэлтийн бүртгэл, төрсний бүртгэлийн лавлагаа, банкны хуулга, таван сая төгрөг байршуулсан гэрээ, түрээсийн болон ажлын газрын тодорхойлолт, төрөл садангийн лавлагаа, оюутны тодорхойлолт, малчны тодорхойлолт... гээд байж болох бүхий л бичиг баримтыг хуурамчаар үйлдэн, виз мэдүүлэх болсныг нэгд нэгэнгүй дурджээ. Үнэхээр монголчуудаас л иймэрхүү заль, үл бүтэх үйлдэл гарна. Тиймээс улс орнууд монгол иргэдэд виз олгохдоо хатуурхаж, цаг их зарцуулахаас аргагүй. Монголын нэр хүнд олон улсад ийм л байна. Үнэндээ бидэнд өмнөд хөршөөсөө харж, суралцах зүйл

Иргэдээ хянадаг Хятадын арга монголчуудад зохино

Хэрэв энэ хуулийг Монголд оруулаад ирвэл өчнөөн сая, тэрбумын зээлээ эргэн төлдөггүй хэрнээ гадаадаар аялж, үнэтэй сургуульд хүүхдээ сургаж, улс төрийн өндөр албан тушаал хашаад байдаг нөхдийн ханд нь дарагдах байлгүй.

Түүнчлэн Хятадын Соёл, жуулчлалын яамнаас авч хэрэгжүүлдэг арга хэмжээ Монголд нэн дутагдалтай байгаа зүйлийн нэг. Тухайлбал, тус улс хилийн чанадад аялахдаа соёлгүй загнасан иргэдийн нэрийг нь зарлах, дахин хилийн дээс алхахыг нь хориглодог. Өөр улсад аялахдаа зодолдох, хулгай хийх, тэр ч байтугай хөшөө дурсгал өөд авирсан бол иймэрхүү шийтгэл амсдаг байна. Түүнчлэн онгоцоор нисэж явахдаа ослын хаалгыг нь санаандгүй онгойлгосон нөхрийг агаараар аялахыг нь хориглосон удаатай. Хилийн чанадад улсынхаа нэрийг хөөдсөн нөхдөд энэ мэтээр арга хэмжээ авч, иймэрхүү үйлдэл дахин давтагдахаас сэргийлдэг аж. Бас л Монголд нутагшуулчихмаар аятайхан санаа.

Ардчиллын буянаар монголчууд хилийн дээс чөлөөтэй алхдаг болсноос хойш бараг гурван арван жил өнгөрчээ. Өдгөө Хойд, Өмнөд Америкаас авахуулаад Африкт хүртэл монголчууд ажиллаж, амьдарч байна. Монгол хүний толгой дээр нар жаргадаггүй гэж хэлэгдэх хүртлээ бидний цөөхөн монголчууд дэлхий нийтэд тархжээ. Гадаад харилцааны яамнаас өгдөг албан мэдээллээр Монголын 140 гаруй мянган иргэн харь улсад төвхнөж байна. Гэхдээ албан бусаар буюу “хараар” амьдарч буй иргэдийг нэмж тооцвол энэ тоо бараг 300 мянгад дөхнө гэж ярьдаг. Ерөнхийдөө 10 монгол тутмын нэг нь өөр улсад амьдарч байна гээд хэлчихэд нэг их хол зөрөхгүй байх.

Гэвч гадагшлах урсгал нэмэгдэхийн хэрээр хилийн чанад дахь монгол иргэдийн

талаарх бараан мэдээлэл чих дэлсэж, нүүр улайлгах нь улам ихсэх боллоо. Хамгийн сүүлд энэ сарын эхээр Тайландад шил дараалан гарсан хулгайн хэрэг байна. Эхлээд Монголын гурван иргэн тус улсын онгоцны буудал дээр хулгай хийж байгаад баригдан нэр, устайгаа зарлуулж, нүүр хийх газаргүй болсон. Гэтэл үүнээс хэд хоногийн дараа Монголын өөр гурван иргэд Тайландын хааны ордон байсан алдартай сүмд америк жуулчдын халаасыг ухааж байгаад үйлдэл дээрээ баригдав. Ер нь Монголоос очсон бүлэг хулгайч тус улсад нэлээд олон удаа хулгайн хэрэг үйлдсэн бололтой. Ингээд олон хавар нэгэндээ гэгчээр хэдхэн хоногийн зайтай ар араасаа баригдав. Энэхүү шившигтэй явдлын дараа Тайланд улс Монголоос ирж буй хүмүүсийг нэмэлт анкет бөглүүлж байж хил нэвтрүүлэх эсэхээ шийдэх журам гаргасан юм. Нэг үхрийн эвэр доргиовол... гэгчээр урт

гартай хэдэн өгөр хулгайчаас болж нийт монголчуудын нэр олон улсад навс унасан нь энэ.

Харь орон дахь монголчуудын үйлдсэн хэргийг энэ мэтээр жагсаагаад байвал нэлээд урт үргэлжлэх болно. ЦЕГ-ын мэдээллээс харвал 2018 онд гадаадад амьдарч буй Монголын 1400 орчим иргэн гэмт хэрэгт холбогджээ. Зөвхөн БНСУ-д гэхэд мянга орчим иргэн гэмт хэрэгт холбогдсон байна. Түүнчлэн БНХАУ-д 253 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 109 нь хулгайн гэмт хэрэг үйлдсэн аж. Одоогоор Монголын 167 иргэн харь улсын шоронд ял эдэлж байгаа юм.

Уг нь гэмт хэрэгт холбогдсон, гадаадад амьдарч байхдаа хэрэг түвэг тарьсан бол гадагш явах виз олгодоггүй. Гэвч монголчууд л болсон хойно яаж ийж аргалаад л хил нэвтрээд байгаа. Бүр хулгайн бүлгийнхэн хоорондоо тохиролцож байгаад бөөндөө гадагш гарч, гадаадынхны халаасыг хоосолдог гэх. Үүний

● **Монголын 167 иргэн харь улсын шоронд ял эдэлж байгаа.**

● **Юу юугүй барьж, хорьж, торгоод байх биш, төрийн үйлчилгээ авах, хилээр гарах зэрэг зарим эрхийг нь хязгаарлахад л дүрэм зөрчигчид номондоо орно.**

● **БНХАУ хилийн чанадад аялахдаа соёлгүй загнасан иргэдийн нэрийг нь зарлахаас гадна дахин хилийн дээс алхахыг нь хориглодог.**

нэгэн илрэл нь сая Тайландад болсон хулгайн хэрэг болж байна. Уг нь улсын нэр хөөдсөн эдгээр нөхдийг л “Зөвхөн Монголдоо” үлдээгээд, гадагш гаргадаггүй болмоор байна. Үүний тулд хил гаалийнхан хяналтаа сайжруулах ёстой. Хэрэв энэ хэвээрээ байвал дэлхий дахинд монгол хүний үнэлэмж, нэр хүнд буурсаар байх болно. Монголоос яваа гэхээр л хил дээр тусгайлан шалгаж, явдал чирэгдэл учруулаад байвал ямар олиг байхав.

Энэ сард БНСУ-ын ЭСЯ-наас гаргасан мэдэгдэл олон нийтийн талцуулж, хэрүүлийн сэдэв болоод амжсан. Тус улсад виз мэдүүлсэн нэг монгол иргэний хүсэлтийг шийдвэрлэхэд дунджаар 70 хоног зарцуулж байгаа нь хэт удаан байна гэх гомдлын хариуд Солонгосын тал монголчуудыг дандаа хуурамч бичиг баримт бүрдүүлж, залилахыг оролддог тул хүсэлтийг нягтлахад цаг их зарцуулж байгааг тайлбарласан

дэндүү их байна. Хэрэв Хятадын тэрбум гаруй хүн өөр өөрийн дур зоргоор авирлавал юу болох билээ. Тиймээс дүрэм зөрчиж, том толгойлдог нөхдөө хянаж цагдаа арга нэвтрүүлж, эхнээсээ үр дүнд хүрлээ. Юу юугүй барьж, хорьж, торгоод байх биш, төрийн үйлчилгээ авах, хилээр гарах зэрэг зарим эрхийг нь хязгаарлахад л дүрэм зөрчигчид номондоо орж байна. Тэгвэл Монголд ч гэсэн Хятадын энэ аргыг ашиглахад буруудах юун. Улс дотроо дур зоргоороо авирлаж, дүрэм журмыг уландаа гишгэдэг байдал бүр хэтэрч, олон улсын шинж чанартай болсныг бид алхам тутамдаа харж байна. Харь оронд хулгай хийж, хэрэгт орж яваа гэднийг хэн нэгэн Болд, Бат биш, монголчууд л гэж ерөнхийд нь нэрлэж, зарлана. Энэ мэт үл бүтэх нөхдийг хатуухан гараар барьж, таарсан шийтгэлийг нь оноож байхгүй бол Монголын талаарх бараан мэдээлэл улам нэмэгдсээр байх нь. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



ЗГМ: Сэдэв

Монгол Улсын усны хэрэглээний 55 хувийг эзэлдэг газар тариалан, МАА-г төлбөрөөс чөлөөлөх нь зөв үү

«1 Гэхдээ үүнд “цагталдад” тайвширч суух учиргүйг бүс нутгийн хэмжээнд усны хомсдол, цөлжилтөөр анхаарлын тэмдгийн урд бичигдэж байгаагаас харж болно. Энэ байдал удаан үргэлжилбэл хар тивийнхний адил харангадах аюул ойрхон бий. БОАЖЯ-наас жил бүр хийдэг усны нөөцийн сан болон гол горхи, булаг шандын тооллого ч үүнийг ёрлоод л байгаа. 2018 оны байдлаар 1495 нуур, гол горхи, булаг шанд ширгэж, цөлжилт нэмэгдэх, томоохон төв суурин газруудын ундны усны нөөц шавхагдах зэрэг бодит аюул тулгарлаа.

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭГЧ /сая тонн/

» Нуур 500
» Мөсөн гол 19.4
» Гол горхи 34.6
» Гүний ус 10.8

БҮРТГЭЛТЭЙ ХУДАГ

» Гүний худаг 19,482
» Гар худаг 29,556

БҮРТГЭЛТЭЙ ГОЛ ГОРХИ, НУУР ЦӨӨРӨМ /2018 он/

» Нуур 3598
▼ ширгэсэн 391
» Гол горхи 5228
▼ ширгэсэн 344
» Булаг шанд 10,472
▼ ширгэсэн 760

С.Батсайхан / ЗГМ©

Усны агентлаг байхгүйгээс ус, гол ширгэх хүчин зүйл ундарсаар байна

Манай орон 564.8 км.куб.жил буюу 564 сая тонн усны нөөцтэй ч үүнийхээ ердөө 500 сая шоо метрийг ашигладаг. Дийлэнх буюу 80 орчим хувь нь хангайн бүсэд, томоохон голуудын хөндийд бүрэлдэн бий болдог ч 70 хувь нь “эх оронч” бус голоор дамжин хоёр хөршүүр урсан одож буй. Сүүлийн үеийн судалгаагаар манай орны экосистем, усны урсцыг дэмждэг нэг эх үүсвэр болох цэвдэг тархах боломжит талбай 50 гаруй хувиар, цэвдэгтэй талбай 5 хувиар буурчээ. Үүн дээр дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас усан гадаргын ууршилт тогтмол нэмэгдэх прогноз ч бидний эсрэг байна.

Монгол орны хэмжээнд усан гадаргын ууршилт 2016-2035 оны хооронд жил дунджаар 107-165 мм, 2050 онд 364, 2080 онд 370 мм-ээр нэмэгдэх судалгааны дүн ч гарчээ. Дээр нь жил ирэх тусам усны нөөц хорогдож байгаа тоо “дотор харлуулна”. Өнгөрсөн жил гэхэд хоёрхон аймгийн хэмжээнд 30 гаруй гол горхи, долоон нуур ширгэсэн байна. Энэ мэтээр аймаг бүрийн ширгэсэн, хатсан усны тоо баримтыг дурдвал гол гогодож, сэтгэл эмээглүүлэх дэг. Муйхарлаж бодвоос хар зураасны гадна бичигдэж дэлхий нийтийн агаархлыг төрүүлж байсан бид хар цагаан хэл ам тусаж усны хомсдол орох өндөр эрсдэлтэй тулгарлаа. Үүний гол буруутан дэлхийн дулаарал гэж өөрсдөөсөө түлхэлгүй, цөлжилт, хуурайшилт хэмээн өөрчлөлтийн тухай

ярилгүй, уруудан доройтож буйн гол шалтгааныг хүний хариуцлагагүй үйлдэл, муу засаглалын үр нөлөө хэмээн онцлон харах цаг хэдийн болжээ. Усны салбар 80 жилийн түүхтэй ч хариуцах эзэнгүй, харьяалах төрийн захиргааны төв байгууллагууд болсноос нэгдсэн бодлого, чиглэлгүй явсаар усны хөгжил доройтлын шатанд хүрээд байгааг салбарынхан хүлээн зөвшөөрч эхэллээ. Өнгөрсөн намар Ерөнхийлөгчийн Тамгын газраас усны талаар хэлэлцүүлэг зохион байгуулах эрдэмтдийн саналыг нэгтгэхэд усны хөгжилд хамгийн их саад болж буй шалтгаан зохион байгуулалтгүй байдал, зохисгүй хэрэглээ гэж дуу нэгтэй гар өргөсөн юм. Монгол Улсын усны салбарын чиг үүргийн хуваарилалт Ерөнхий сайдын болон 10 яам, хоёр агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хуваагдсан нь усаа хамгаалах, нөөцлөх, дахин ашиглах, говийн бүс нутгийг усжуулах, уул уурхайн салбарт ашиглаж буй усны зохистой хэрэглээг хангах, хянах зэрэг ажил эмх, замбараагаа алдсаны шалтгаан болж байна. Гэлээ гэд өнөөдөр өмнөхөөс өөрчлөгдсөн зүйл алга. Ерөнхийлөгчийн зүгээс усны салбарын бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, усны агентлаг байгуулж тулгамдаж буй аюулыг гэтлэх талаар онцгой анхаарал хандуулж тууштай ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосон ч ажил хэрэг болж, ард нь гарсан ахиц

алга л байна. Салбарын яам, усаар дагнадаг эрдэмтэд ус бохирдуулсны төлбөрийг салбар бүрт нэмэх хүсэлт илгээхэд УИХ дахь МАН-ын бүлэг сонгуульд оноо цуглуулах зорилгоор зарим салбарыг бүрэн чөлөөлөх гээд “попроод” сууж байна. Манайх шиг хүн ам, газар тариалан, МАА-г усны төлбөрөөс чөлөөлдөг орон байхгүй. Тэгээд ч газар тариалан, МАА-н салбар манай улсын нийт усны хэрэглээний 55 хувийг эзэлдэг гэхээр тэр хэрээр цэвэр усны нөөцөөс хороож байгаа хэрэг. Усны нөөцийг нэмэгдүүлэх гол ажлын нэг усны хайгуулын ажил ч хөрөнгө мөнгөний татуугаас сүүлийн жилүүдэд эрс буурсан. Гэтэл нөхцөл байдал жил ирэх бүрид дордож байхад төрийн бодлого нь усны хөгжлийнхөө эсрэг яваад байгааг ойлгоход бэрх.

Хоёр хөрш маань усны асуудал хариуцсан яам байгуулж түүгээр дамжуулан төрийн бодлогоор усны хөгжлөө ундруулж байна. Харин манайх агентлаг ч атугай байгуулахын оронд усыг улс төрийн “зэвсэг” болгон ашиглахаар төлөвлөж байна. Үүний оронд гол горхи, булаг шандаа хамгаалах мөнгө босгох аргыг сэтгэвээс зохилтой баймаар. Өмнө баталсан хуулийн буруугаас, бодлого зангидах төрийн захиргааны байгууллагуудыгээс усны хамгаалалтад зориулах мөнгө орон нутгийн удирдлагын гарын салаагаар урсаад өнгөрч буй жишээг ч мэргэжлийн байгууллагынхан ярьж байна.

ЗГМ: ТОДРУУЛГА

Л.Эрдэнэбулган: Орон нутгийн удирдлагууд ус хамгаалах мөнгийг өөр зүйлд зарцуулдаг



БОАЖЯ-ны Усны нөөцийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбулганаас гол горхи ширгэхэд нөлөөлж буй хүчин зүйл хийгээд усны бодлого зангидах агентлаг байгуулах ажил ямар шатанд байгааг тодрууллаа.

-Гол горхи, булаг шанд ширгэж байгаагийн гол шалтгаан юу вэ?

-Мэдээж уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай салшгүй холбоотой. Зарим бүс нутагт хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гол горхи ширгэж байгаа. Уул уурхай, газар тариалан, МАА-ын салбараас мөн шалтгаалж байна. Уул уурхайн салбар усны нөөцөд нөлөөлөх нь ойлгомжтой. Газар тариалангийн салбар улсын усны хэрэгцээний талаас илүү хувийг эзэлж байна. Мөн малын хөлөөр булаг шанд ширгэх гол шалтгаан болж байгаа.

-Үүнийг хамгаалахад бодлогын ямар алдаа байна вэ?

-Уг нь усны салбарын хууль эрх зүйн орчныг сайн бүрдүүлсэн гэж гадны экспертүүд үнэлдэг. Гэвч хуулийн заалтууд хэрэгжихгүй байгаагаас хамгаалалтын ажил урагштай байж чадахгүй байна. Хуулиар ус ашигласны төлбөрийн 35 хувийг ус хамгаалахад зориулах болсон.

Усны төлбөрт жилд 44.6 тэрбум төгрөг ордог ч дөнгөж 3.9-ийг нь усанд зарцуулжээ

Тухайлбал, өнгөрсөн онд ус ашигласны төлбөрөөр 44.6 тэрбум төгрөг олсон. Үүний 16.3 тэрбумыг ус хамгаалах ажилд зориулах байтал 3.9 тэрбум төгрөг л зарцуулсан байна. Үлдсэнийг нь орон нутгийн удирдлагууд өөр зүйлд дур мэдэн зарцуулж хууль тогтоомжийг хэрэгжилт 23 хувьтай маш хангалтгүй байгаа

гэсэн үг. Энэ нь усны салбарыг хариуцсан төрийн захиргааны байгууллага байхгүйтэй холбоотой.

-Усны агентлаг байгуулах ажил ямар шатандаа явна вэ?

-Агентлаг байгуулахаар хуулийн төсөл санаачилж Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд болон манай яамны сайд нар үзэл баримтлалыг нь баталсан. Засгийн газрын хурлаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих ажлыг хууль тогтоомжийн дагуу хийж байна.

-Танайхаас МАА, газар тариалангийн салбараас ус бохирдуулсны төлбөр авах хуулийн өөрчлөлтийг УИХ-д өргөн барьсан ч дэмжсэнгүй. Ингэснээр хэдэн төгрөгийн боломж үгүй болов уу?

-Хуулийн төслөөр нэг хонин толгойд оногдох жилийн төлбөрийг гүний усанд 426 төгрөг, гадаргын усанд 19 төгрөг байхаар тооцож байсан. Харин газар тариалангийн хувьд га тутамд гүний усанд 86 төгрөг, гадаргын ус ашиглавал 13 төгрөг байхаар тусгасан байсан. Харамсалтай нь ажлын хэсэг болон бүлгээс дэмжлэг авч чадсангүй. Хэрэв энэ төлбөр ордол ус хамгаалах, 21 сав газарт илүү хөрөнгө оруулалт хийх боломжтой болох байлаа. [ЗГМ]

ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:

“Өргөтгөлийн барилгын зураг төсөл” боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: 2019/ЗУ-3Т1

ҮХЦТГ эрх бүхий тендер оролцогчдоос “Өргөтгөлийн барилгын зураг төслийн ажил” боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийг 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө ирүүлэх ба 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 11 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11 дүгээр хороо, Зайсангийн гудамж, ҮХЦТГ,
1 дүгээр давхар, 106 тоот өрөө.
Утас: 92260082, 92260055, 88114022.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.04.24

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Багахангай дүүргийн өндөрлөг байгуулах тохижилтын ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: БХД-01/19

Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендер оролцогчдоос Багахангай дүүргийн өндөрлөг байгуулах тохижилтын ажил-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг татаж авна уу. Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 (Тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Барилга хот байгуулалтын яамны:

Хуучнаар БУ-н 2.1.1*, 2.1.1, 2.1.2 болон шинээр БА-н 4.1, 8.1-н аль нэгийг хангасан байх
Тендерийн хамт 1 484 748 /нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга долоон зуун дөчин найман/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.
Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хүчинтэй байна.
Тендерийг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 11 цаг 00 минут-аас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 11 цаг 30 минут -т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй
Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо, хорооны байр 2 давхар,
207 тоот Худалдан авах ажиллагааны алба, мэргэжилтэн Э.Урансайхан,
Утас 70491050, 99443390 Цахим хаяг: www.tender.gov.mn

Үзэл бодол

ЕТГ-ын дарга З.Энхболдод бичсэн нээлттэй захидал



И.Цэрэнхүү
Социологич, памфлет нийтлэлч

Төр улсын тогтолцооны талаар сонирхдог өчүүхэн бичээч би таны амар мэндийг асуун мэндчилж байна.

Миний суурь мэргэжил эдийн засагч. Эзэмшсэн мэргэжилдээ дулдуйдан улс орны эдийн засгийн чадамж, боломж, нөхцөл бололцооны талаар үзэл бодлоо хэлэхийн ялдамд таны гурван жилийн өмнө хөндөж байсан маш чухал асуудлыг эргэн сануулах гэсэн юм, ердөө энэ.

1. Эдийн засаг жил бүр өсөлттэй гарч байгаа ч харьцангуй талаас нь үзвэл үнэхээр өсөлттэй байгаа юу. Ард түмний бодит орлого өсөөгүй, харин ч буурсан. Эдийн засаг бүхэлдээ урьд хожид байгаагүй их өрийн дарамтад уналаа. Улс орныг тогтвортой авч явдаг дундаж давхарга өндийх найдвар тун бага байна. Эдийн засгийн өсөлтийн суурь үзүүлэлтээр цалин, тэтгэвэрийг индексжүүлэхгүйгээр ард түмэнд цалингаар амьдарна гэсэн ойлголт алга болсон. Цалин хангамжийн дефицитээс болж иргэд өрийн гинжин сүлжээнд орсноос түгээмлээр ядуурлаа. Тэгэхээр эдийн засаг харьцангуй үзүүлэлтээр макро түвшиндээ өссөн гэдэг нь худлаа болж таарч байна. Эндээс гарах хамгийн найдвартай арга зам бол “Эдийн засгийн суурь бүтэц” (дэд бүтэц хэмээн гажуу нэрлэж хэвшсэн)-ийн аль нэгийг түлхүү хөгжүүлж, хөгжлийн стратеги болгон зарлах явдал юм хэмээн ойлгодог. Энэ утгаар Алс Дорнодын цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдох саналыг зөв бодлого хэмээн дэмжиж байна.

2. Мэдээж эрчим хүчээр дотоодын хэрэгцээг хангаж, бас импортлоно хэмээх үг сайхан л сонсогдож байна, тийм боломж ч байгаа байх. Гэхдээ дотоодын хэрэгцээ гэдгийг юу гэж харж байна. Нийлүүлэлт дагаад хэрэгцээ өсдөг гэсэн эдийн засгийн хууль байдгийг та юу эс андах вэ. Шинэ хэрэгцээ мөр мөрөө даган орж ирнэ. Үүнтэй уялдуулаад нэг санаа дэвшүүлэе. Энэ нь малчдын амиа аргацаасан аж ахуйг эрчим хүчний тусламж дэмжлэгтэйгээр таваарын жижиг үйлдвэрлэлд шилжүүлэх тухай санаа. Малчны суурь бүрт, өвөлжөө болгонд эрчим хүчний хангамжийг хүргэмээр байна. Энэ замаар малын гаралтай түүхий эдийн таваарлаг чанарыг бий болгож болно гэж бодох юм. Малчны хотхонд өрх айл болгон үйлдвэрлэгч болох ёстой. Герман, Австри, Франц ч өрхийн үйлдвэрлэлийг онцгойлон авч үзэж, жижиг оврын техник төхөөрөмжийн үйлдвэрлэлээ эрчимжүүлээд эхэллээ.

Мал аж ахуйг суурь салбар болгон тунхаглаж, улмаар ажил болгох гэсэн Е.Энхболдын санаа одоо ч ач холбогдлоо алдаагүй хэвээр байна.

sonin.mn/blog/tserenkhuy/59415

3. Энхболдын дэвшүүлсэн концепц

Би бээр З.Энхболдын өмгөөлөгч, магтан дуулаачийн аль нь ч биш, тийм шаардлага ч мань мэтгэд байхгүйг эхлээд хэлье. Хувь хүн талаас нь түүнийг мэдэх ч үгүй, хумсаа хүртэл нууж явахаас аргагүй, дээр нь бодол санаагаа шулуухан хэлдэг хүн хомс болчихсон энэ гажуу цаг үед нял шал гэлгүйгээр, эмоцио хүртэл нуулгүйгээр хэлэх юмаа шуудхан хэлчихдэг нь зүгээр ч юм уу гэж бодогддог. Төрийн том хүний үг бол үндсэндээ үйлдэл. Түүний нэг цэг хэмээн соёрхгооно уу.

Тэргүүний малчдын Улсын Зөвлөлдөөн (Зөвлөгөөн биш) дээр, УИХ-ын дарга З.Энхболдын хэлсэн үгийг анзаарахгүй өнгөрч чадсангүй. Анхаарал татсан гойд зүйл нь гэвэл, өнгөрсөн 25 жилийн туршид, эдийн засгийн хөгжлийн стратегийн концепцын ноцтой алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, шинэ концепц

дэвшүүлсэн дээд удирдлагын түвшний анхны улстөрчөөр тэр гарцаагүй тодорлоо. Төрийн чухал хүний хэлсэн үгийг судалж, танин мэдэхүйн үндэслэлүүдээр тайлбарлахыг интерпретаци гэдэг. Түүний хэлсэн үгэнд, мэргэжилдээ индекжүүлэхгүйгээр ард түмэнд цалингаар амьдарна гэсэн ойлголт алга болсон. Цалин хангамжийн дефицитээс болж иргэд өрийн гинжин сүлжээнд орсноос түгээмлээр ядуурлаа. Тэгэхээр эдийн засаг харьцангуй үзүүлэлтээр макро түвшиндээ өссөн гэдэг нь худлаа болж таарч байна.

ТАВАН ХОШУУ МАЛЫН ТУХАЙ КОНЦЕПЦЫН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү концепц нь малын тухай байдаг л нэг асуудал дэвшүүлсэн үзэл баримтлал төдий зүйл биш юм шиг байна. Гахай, шувууг оруулаад долоон хошуу малтай больё, бэлчээрийнхээ суурин фермерийн аж ахуй руу зорилт шилжье... гээд янз янзын зорилт дэвшүүлжээдэг байсан. Гэтэл энд арай том зураглал, макро эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбарын асуудлыг хөндлөө гэж ойлгож байна.

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар юу вэ гэвэл “Уул уурхай” хэмээн хэнобугай ч төвдөхгүй харилна. Стратегийн орд гэх чамин цолтой энэ салбарыг би хэдэн ч удаа толин тусгалт (situs inversus) гэж салбар хэмээн хүчтэй шүүмжилж байв. Харахад их гоё, үр дүн нь толины тусгал шиг урвуугаар буудаг болохоор нь тэр л дээ. Борлуулалт шүтсэн, зах зээлийн үндэс боолчлогдсон салбар л даа хөөрхий. Ийм салбарт, “стратегийн” гэх сүрхий нэр өгч, тэргүүлэх салбараараа өргөмжилсөн нь 25 жилийн түүхийн үнэхээр том алдаа. Ард нь олигархиуд байгаа болохоор зориудын алдаа гэх нь дээр байх.

К О Н Ц Е П Ц И Г Ү Й Н АЛДАА <http://sonin.mn/blog/tserenkhuy/57344>

3. Энхболдын эшлэлээс:

“Улс орны онцлогоор уул уурхайн мэдээлэл цаашид ч гэсэн чухал салбар болон үлдэх нь дамжиггүй ч тэргүүлэх ч гэдэг юм уу суурь салбар гэхээр хөнгөн үйлдвэр, МАА хоёрын аль нэгийг сонгохоос өөр гарц байхгүй л дээ. Энд нэг логикийн юм ажиглагдаад байгаа нь юу вэ гэхээр хөнгөн үйлдвэр дагуулж МАА хөгжүүлэх амаргүй, харин МАА-н хүрээнд хөнгөн, хүнсний аж үйлдвэрээ хөгжүүлэх бүрэн боломжтой. Тэгэхээр, МАА-г суурь салбар гэж төрийн бодлогын түвшинд зарласан нь санамсаргүй зүйл биш, цаг орон зайгаар онож олон концепц. Энэ бол аргагүй том концепц”.

“Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр бий болсон уул уурхайн түүхий эдийн үнийн уналт манай эдийн засагт хүчтэй цохилт болж, бидэнд хөгжлийн талаар нэгийг бодогдуулж, дан ганц уул уурхайд суурилсан эдийн засагтай байж болохгүй гэдгийг хатуу ухааруулж байна. Монгол Улсын хөгжлийн үндэс нь хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбар гэдэг үзэл баримтлалыг Ардчилсан намаас төрийн бодлого болгон дэвшүүлж байна”.

МАА бол эдийн засгийн суурь салбар мөн гэж төрийн бодлогын хэмжээнд тунхаглах хэд хэдэн үндэслэл байгаа аж.

1. МАА бол монголчуудын

соёл, аж ахуй эрхлэлтийн түүхэн уламжлал.

“Монголчууд бид хэдэн мянган жилийн өмнөөс бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэн амьдарч ирсэн баялаг уламжлалтай ард түмэн.”

2. “МАА-н хөгжил нь бусад салбар хөгжих суурь, хөрс нь болон үйлчлэх боломжтой, монголчууд бид мал аж ахуйгаа хөгжлийн үндэс болгох учиртай”

3. Монголчуудын нэлээд хэсэг нь шууд, үлдсэн хэсэг нь шууд бусаар МАА-тай холбогдог. Мах иддэггүй монгол хүн олоод ир гэвэл огт хоол иддэггүй хүнийг эрсэн нь хялбар байлгүй дээ.

Энэ салбарыг хөгжүүлэх нь олон айл өрхийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгодог. Хөдөө аж ахуй бол манай улсын нийт ажиллах хүчний дөрөвний нэгийг багтаадаг, нийт өрхийн талаас илүү хувь нь энэ салбараас хамааралтай амьдардаг эдийн засгийн томоохон салбар тул олон мянган айлын орлого нэмэгдэнэ”

4. ХАА-г хөнгөн хүнсний үйлдвэрлэл хөгжих суурь бүтэц болгох нь илүү ашигтай гэдэг нь гаднын туршилт, туршлагаар ч нотлогдсон зүйл.

Амиа аргацаасан арга, эрчимжсэн технологийн шинэчлэлд гологдоно

“Ялангуяа аж үйлдвэржилтийг амжилттай хөгжүүлсэн Азийн орнуудын жишээг харахад эхлээд хөдөө аж ахуйн салбараа онцгой анхаарч, хөгжлийн гараагаа эхлүүлжээ. “Дэлхийн II дайны дараа Япон улс эдийн засгаа хурдан босгохын тулд юуны түрүүнд газар тариалангийн салбараас эхлэн эрчимтэй шинэчлэл эхлүүлсэн. Төрийн нэгдсэн бодлогоор ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлсэнээр хүн амынх нь орлого нэмэгдэж, дотоодын зах зээлээ томруулан бэхжүүлсэн байна. Энэ нь аж үйлдвэрийн бусад салбараа хөгжүүлэх үндэс болж улмаар Япон улс дэлхийд тэргүүлэгч болсон.”

5. Монголын уламжлалт МАА-н давуу тал нь бэлчээрийн ургамалд байгаа юм. Мал хөөж, сорчилж иддэг ургамлуудыг голчлон анхаарч, манай судлаачдын зүгээс Орос, Буриадын эрдэмтдтэй хамтран хийсэн судалгааны үр дүн үүнийг нотлон харуулдаг. Энэ давуу талыг ашиглан эдийн засгаа өөд нь татаад авах нь монголчуудын хувьд чимээгүйгээр өнгөрөөж боломгүй заяагдмал боломж.

“Онгон зэрлэг байгаль дээрээ аргаль, янгир гэх мэт зэрлэг амьтадтай адил өвс ногоо иддэг тул монгол малын мах онцгой амт чанартай гэдэг нь нэгэнт шинжлэх ухаанаар батлагджээ. Энэ давуу талаа ашиглан өндөр үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд нийлүүлэх зорилтыг дэвшүүлж байна”

Энэ дашрамд өгүүлэхэд, байгалийн хүнд нөхцөлд

онцгой чанарын ургамал ургадаг нь үндэслэлтэй зүйл. Францын Кристиан Диорын үндсэн түүхий эд гэгдэх тосыг Сахарын цөлд ургадаг ховор цэцгээс гаргаж авдаг. Хулан, тахь гагцхүү Монголын говьд л үржинэ. Германчууд монгол адуу аваачихсан, Мюнхений ойролцоо өсгөж, яаж ч оролдоод айраг гаргаж чадахгүй байна. Тэр фермер монгол ажилчидтай юм билээ. Айраг, гадаад улс оронд бүү хэл Монголын зарим аймаг, нутагт ч эсэхгүй байх нь бий гэх мэт ийм жишээ үй түмээр нь дурдаж болно.

КОНЦЕПЦЫН НИЙГЭМ ЗҮЙН ТАЛ

Тал гэх юмгүй, МАА-г тэргүүлэх салбар болгоно гэсэн концепц нь өөрөө нийгмийн асуудлыг бүхэлд нь хөндөж байна. Нийгмийг хөдөлгөх том хөшүүрэг бол “Татвар”. Малчдыг татвараас чөлөөлөх арга хоцрогджээ гэдгийг онцлон дурдья, бид татвар төлөх эрхгүй хүмүүс үү гэсэн асуулт малчин хүний амнаас гарч байсныг санаагаа байгаа. Энэ бол улстөрчдийн сэтгэлгээ хөдөө нутгийн малчин хүний тэмүүлээс ч доогуур түвшинд байгааг харуулсан бодит жишээ. ХАА-н татвар гэсэн эрх зүйн шинэ орчин үүсгэх цаг, шаардлага болон ирж байна.

МАЛЫН ТАВААРЛАГ ЧАНАР

МАА-д нэмүү өртөг үүсгэх таваарын өргөтгөөн үйлдвэрлэл босгож, түүнийг эрчимжүүлэхгүйгээр энэ бодлого хэрэгжих боломжгүй.

“Бэлчээрийн мал аж ахуйтай орчин үеийн фермерийнхээ менежментийг мөн ослуулж хөгжүүлэх нь зүйтэй” гэж З.Энхболд хэлсэн.

Энэ том зорилтыг дан ганц эдийн засаг талаас нь харвал бүтэмж муутай. Хуучнаар ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэл

гэдэг байсан, одоо бол хүний нөөцийн тасралтгүй нөхөн үйлдвэрлэлийг чанартай хийх ёстой. Залгамж халааг алдаж болохгүй, үүний тулд анхаарлын голыг хүн рүүгээ чиглүүлэх ёстой. Энд дан ганц халамжийн бодлого явуулаад, эсвэл тэртэй тэргүй төлдөггүй татвараас нь чөлөөлнө гэж яриад нэмэр болохгүй. Малчин гэдэг ерөнхий нэршлийг халж, МАА-н ажилчин, мэргэжилтэн категорид хамруулж, цалинтай, татвартай, хариуцлагатай хөдөлмөрчид бойжуулан гаргаж ирэх ёстой.

НЭМЭРЛЭХ САНАА ОНОО

Монголчууд мал маллахаа мэдээж хэнээр ч заалгахгүй, гэхдээ МАА-н бүтээгдэхүүнийг тавааржуулах тал дээр үндэсний болоод гаднын шинжлэх ухааны байгууллагууд, судалгааны институтуудтэй нягт хамтран ажиллах ёстой. Надад бодогдож явдаг, хэлчихмээр ганц нэг юм байна.

1. Малаас гарах түүхий эд, эцсийн бүтээгдэхүүнд нэмэгдүүлсэн өртөг аль болохоор, боломжоор шингэж явах ёстой, тэгж гэмээ нь мал аж ахуй бүхэлдээ таваарлаг болж чадна. Амиа аргацаасан арга, эрчимжсэн технологийн шинэчлэлд хөндөгдөнө. Орос, Монголын эрдэмтэд мал, малын бэлчээрийн даац, ургамлыг хангалттай судалсан. МАА-г тэлэх биш эрчимжүүлэх шаардлага судалгааны дүгнэлтүүдээс гарсан байдаг. Бүтээмжийг өсгөх чиглэлээр эрчимжүүлэх тавааржуулах эрэл хайгуул хийх нь орчин цагийн хамгийн чухал зорилт ч байж мэднэ.

2. МАА-н брэнд бүтээгдэхүүн дэлхийд гарах ёстой. Мэдээж ийм боломж байгаа, учир нь манай бэлчээрийн малын мах, сүүний найрлагын шимт бодис бусад улс орнуудаас хавьгүй өндөр байдаг. Итали, Франц зэрэг гоо сайхны бараа үйлдвэрлэлээр

дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн орнууд манай адууны махыг их авдаг. Бас Европын өвлийн спортын хамгийн дуртай тэмцээн бол цана, трамплин. Тамирчид дотуураа ноолууран трико өмсдөг, Италийн хувцас хүнд, эдэлгээ муутай гэж олимпын мульта медалийн эзэн, дэлхийн дөрвөн удаагийн аварга А.Малыш ярьж байхыг сонссон юм.

3. Гаднын туршлага, ялангуяа нано өндөр хөгжихсон Австрали зэрэг орноос бэлэн аваад хэрэгжүүлчихмээр туршлагыг шууд нэвтрүүлээр байгаа юм. Ганц жишээ хэлье. Австралиас хонь ачиж гарсан хөлөг онгоцон дээр жижиг үйлдвэрлэл явагдаж Япон, Африкийн Марокко зэрэг оронд хүрэхдээ, бэлэн нано бүтээгдэхүүн, бордоо буулгаад буцдаг гэсэн. Манайх Увс, Ховдоос сүү ачиж гараад УБ-д савласан сүү буулгадаг, мах ачиж гараад, зуур аймгуудад түүхий эдийн нөхөн бэлтгэлээ хийсээр, үйлдвэрлэсээр УБ, Дарханд консерв буулгадаг суурин бус жижиг үйлдвэр ТИР ашиглан хийж яагаад болохгүй гэж.

4. МАА-н дистрибутор (distributor), брэнч (branch) жижиг үйлдвэрүүдийг үй олноор нь нээх. Энэ хоёр бол менежментийн нэг чиглэл. Дистрибутор жижиг үйлдвэрүүдийг Орос, Хятад, Япон, Франц, Герман гээд манайхаас МАА-н бүтээгдэхүүн импортлох сонирхолтой орнуудад байгуулна гэсэн үг. Гадаадад суугаа иргэдээ энд ашигласан ч болно. Брэнч үйлдвэр гэхээр деталиар төрөлждөг хэлбэр их модоо болж байгаа юм байна. Дэлхийн брэндийн хувцас үйлдвэрлэдэг том пүүсийн нэгхэн төрлийн товчийг үхрийн эврээр хийнэ гэдэг ч юм уу. Саяхан Польшийн нэг брэнч жижиг үйлдвэрийн тухай нэвтрүүлэг гарлаа. Францын байлдааны онгоцны ганцхан диодыг хийдэг юм билээ, түүхий эд нь зөвхөн Польшид л байдаг, бас тогмол өндөр орлоготой. Тоёото машины ганцхан деталийг УБ-т хийдэг жижиг үйлдвэрийн эзэн Долгормаа гээд залуутай танилцан ярилцаж байсан. Ийм брэнч үйлдвэрүүдэд борлуулалтын зах зээл эрэх шаардлага байдаггүй давуу талтай. Мөн эх үйлдвэрээс нь технологийн шинэчлэлийг их шуурхай хийдэг юм. Энэ бол МАА-д хамгийн тохиромжтой менежмент.

Малдаа сүнсгүй хайртай монголчуудад, МАА-гаа өөд нь татна гэхээр Америкийн ямар ч гайхамшгуудтай зүйрлэхийн ч аргагүй ойр, дотно, дулаан бүлээн санагдаж байна. Гэхдээ өнөөдөр “Үгийг үйлдэл болгох” юунаас ч чухал байна. Үйлдэл болгохын тулд юуны өмнө “Эс үйдэл” гэж тийргэнгээс салах, мөн “Эв нэгдэл” гэгчийг бүх шатанд эргүүлэн тогтоомоор байгаа юм. Газраа ухааж жаахан юм гаргаа л их мөнгө бэлнээр ороод ирлэг юм шиг фикус үзэгдэл харагдуулаад байдаг уул уурхайд “Хойшоо бай” гэж хэлэх цаг нь болсон. Улстөрчид өө, одоо болыгдоо цаг нь болжээ. Монголчууд эвтэй байхдаа хүчтэй шүү дээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.04.24

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Хуванцар усан сан /8тн багтаамжтай/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2019-156

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос хуванцар усан сан /8тн багтаамжтай/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2017, 2018/ тус бүр тухайн барааны төсөвт өртөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 1,800,000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгний тендерийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 08 дугаар сарын 6-ны өдрийг дуустал.

Тендерийг 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн захирал бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

ZGM DAILY

Standing Committee discusses bills on explosives

Working group to be set up to review the bill.

Future Heritage Fund reserve reaches MNT 255.9 billion

This year's budget to allocate MNT 1.9 trillion into the fund.

First-ever closed bond Mabu launches

Mabu bond transactions on the non-stock market began on Monday.

Top 20 index falls 0.16 percent, to 19,836.03 points

Market cap stands at MNT 2.29 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

At the Parliament's Standing Committee on Budget, the draft resolution on approval of State Audits 2019 and 2020 plan was discussed and resolved.


The first parliamentary discussion of the Metrology Law submitted by the Parliamentary Economic Standing Committee yesterday.

ECONOMY

Mongolian Mining Corporation sold 999,600 tons of washed coking coal in the first quarter, up 55 percent from the same period of last year.

Mongolia Third Neighbour Trade Act to be reintroduced by U.S senators.

Top 20 index falls 0.07 percent, to 19,867.14 points. MSE A index decreases 0.37 percent to, 8,746.12 points. MSE B index increases 0.53 percent, to 8,141.77 points. Market cap stands at 2,30 trillion.



SOCIETY

The Central Library of Ulaanbaatar, which is named after Natsagdorj Natsagdorj hosts book event in accordance with World Book Day.

Mongolian athletes win one gold medal and two bronze medal at the International Karate Friendship 2019 & The 36th All Japan weight category championships.

Mongolian athletes take second place in the Asian Judo Championships 2019.

The price of water for households and enterprises in six districts of the capital city to be increased from May 1st.

Standing Committee discusses 2008 bill and postpones it



The draft Law on Allocation were held at the Standing Committees on Security and Foreign Policy.

Batsaikhan.S / ZGM©

Working group established to revise bill on explosives

Aminaa.U
ZGM

The first discussion on the draft Law on the Supervision

of Circulation of Explosives and Blasting Instruments submitted by Cabinet on December 04, 2008, and the draft Law on Allocation were held at the Standing Committees on Security and Foreign Policy yesterday.

As of today, there are 64 licensed entities importing, producing and selling explosives and blasting materials and the development of these products are likely to increase due to the need in the mining sector.

However, the assessment on the consequences of the law does not specify the legal requirements for the licenses, or the professionally accredited bodies, and the functions of law enforcement agencies are not determined including the legal status of the law. It has a negative impact on the implementation of the law, the committee concluded.

Therefore, the majority of the members of the Standing Committee agreed to postpone the bill

and decided to set up a working group.

At the standing Standing Committee meeting, the members also discussed the bilateral agreement between Mongolia and the Republic of Belarus on Friendly Relations and Cooperation.


The 2016-2020 Action Plan of the Mongolian Government states to extend traditional relations and cooperation with third neighbors and other countries.

It also prioritizes the development of trade and economic relations. For this purpose, it is necessary to develop relations, cooperation, trade and economic partnerships with the Republic of Belarus, which is the main center of transit transportation that connects Mongolia with the countries of the Eurasian Economic Union, including our partnering countries in the region, the Ministry of Foreign Affairs emphasized. [ZGM]

FX MARKET


USD/MNT

(one month to date)




RUB/MNT

(one month to date)



CNY/MNT


(one month to date)



ZGM: INTERVIEW

Myagmardorj Enkhmend: Power plants restrain renewable energy industry development

The future of renewable energy projects cost will be lower than before as a result of technology costs reduce.



Dashnyam.B
ZGM

The Official Gazette had a chance to sit with the Secretary-General of Mongolian Renewables Industries Association Myagmardorj Enkhmend to hear his thoughts on the development of renewable energy in Mongolia.

-Mongolia is aiming to draw about 30 percent of its power source from renewable energy by 2030. What is the potential for further expansion?

-Renewable energy sources make up 18 percent of the installed capacity of Mongolia's energy system. However, the percentage of output remains at only 5 percent. By the end of this year, the amount of renewable energy in the installed capacities is expected to reach 20 percent, and the production is estimated to exceed 10 percent.

-The global cost of renewable energy is decreasing. What about Mongolia?

-For solar and wind energy, the equipment makes up about 45 percent of the total cost. The shrink in global cost will lower this num-

ber. However, for example, even if the global cost falls 20 percent, it will not have the same effect for Mongolia.

-In some countries, households generate renewable energy via solar panels. How much of this opportunity exists in Mongolia?

-There are already households that supply 70-80 percent of its electricity consumption from solar energy. The Ministry of Energy had set up a working group to develop a procedure for purchasing surplus power from users. It has been two to three years since then, but the bill has not been approved yet. If this

regulation is approved, households will be able to sell their energy over the network for some income.

Renewable energy is 18 percent of the installed capacity

-The electricity price is relatively low in Mongolia. Does traditional energy production prevent the development of renewable energy?

-Yes, they do. Thermal power plants that provide over 90 percent of total energy consumption do not cover investment costs. In addition, the government provides some support to coal transportation from mines. Because these costs are not included in the users' fees, consumers only pay operating costs. It makes electricity cheaper. However, renewable energy, which is developing based on the market system, is relatively expensive compared to that.

The future of renewable energy projects cost will be lower than before as a result of the reduction in technology costs. [ZGM]

STOCK MARKET

First-ever closed bond "Mabu" launches

Covent TM launched the first closed-bond Mabu. It will be traded on the non-exchange market. Covent TM sells Mabu student bags and a board game.

The annual sales of the company averages at MNT 100 billion in the domestic market. About 30 entities including Brickland, E-Mart, and Nomin make up 49 percent of it, other small retail stores that are not registered at Customs, make up about 50 percent. The remaining one percent

was by national game sales, the company estimated.

In addition, the Covent TM company, which now holds one percent of the students' baggage market, is targeting to expand its market share to 4-5 percent over the next five years.

Mabu bond transactions on the non-stock market began on Monday. The exchange will start receiving subscriptions from April 26, according to the Mongolian Securities Exchange. [ZGM]

FINANCE

MNT 255.9 billion revenue was raised in Q1

Aminaa.U
ZGM

As of the first quarter of 2019, the Future Heritage Fund financing reached MNT 255.9 billion, which is a 118.3 percent growth compared to the same period of the previous year, the Ministry of Finance reported.

This year's budget allocated MNT 1.9 trillion to the Future Heritage Fund. However, the fund inherited the debts of its predecessor Human Development Fund. Thus, the fund will have about MNT 550 billion

after settling the debt this year.

"The money accumulated in the Future Heritage Fund will not be spent until 2030. It is a logical law to put this money to circulation from 2030 onwards. Also, it is important to place the underground resource into a monetary asset," the Ministry of Finance explained.

According to its structure, natural resources royalty may provide more than 70 percent of the Future Heritage Fund. Share dividends of state-owned companies in the mining sector will make up the remaining 30 percent. [ZGM]

Өдрийн хэмнэл

ЗУРХАЙ



Билгийн тооллын 20
Хаврын адаг шар луу сарын дөрвөн ногоон мэнгэтэй цагагчин туулай өдөр
Үс засуулбал: Өлсөж ундаасна
Наран ургах, шингэх: 05.48-19.54
Барилдлага: Рашаан
Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй
Суудал: Хий

Аргын тооллын дөрөвдүгээр сарын 24. Буд гараг. Билгийн тооллын 20. Гар одтой, цагагчин туулай өдөр.

Өдрийн наран 05.48 цагт мандан, 19.54 цагт жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сэвтэй газар очих, уул овоо тахирад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсоод урагш мөрөө гаргавал зохистой.



Ж.Пуччини "Тоска" дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.04.28-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



"Chamber Music Concert" концерт
Хаана: Улсын Филармони
Хэзээ: 2019.04.26, 27-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮25 мянга



Э.Чойдог "Шарилжин дундах цэцэг", Н.Римский-Корсаков "Щехерезада" бүжгэн жүжиг
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.04.27-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Намуухан" уран сайхны кино



Намуун бол дуу зохиодог залуухан охин ба хөгжимд дурлах хүслийг нь юу ч зогсоошгүй мэт хөдөлмөрлөнө. Нэгэн өдөр түүнд нам гүм тайван орчинд бүтээлээ туурвих боломж олдон явснаар энгийн нэг даруухан, ажилсаг залуутай учирдаг. Тэд анхны харцаар

бие биедээ татагдсанаар бүх зүйл төсөөлшгүй сайхнаар өрнөнө. Намуунд Дөлгөөнтэй байхад дэлхий ертөнц зогссон юм шиг санагдан түүнд улам илүү хайртай болно. Тэдний гайхалтай түүхээс сэтгэл уярам хайрын дуунууд хэрхэн бүтэж байгаа талаар уг кинонд

өгүүлдэг. Найруулагч Г.Баттувааны бүтээл "Намуухан" уран сайхны кино дөрөвдүгээр сарын 12-ноос кино театруудын дэлгэцнээ гарч эхэллээ. Киноны гол дүрд залуу жүжигчин М.Намуун, Г.Тэнүүн нар тогложээ. [ЗГМ]



"Carmencita" концерт
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.01-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 50 мянга



"Мөнхийн хүсэл" сонгодог концерт
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.02-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга



Б.Шарав "Чингис хаан" дуурь
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.05.04-ний 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ЗГМ: СУДОКУ

			2	7	1	5
5	9				8	
			5			2
		1	8		5	
					6	
	4			1		
4	7	5				9
8		3				
1		9		8		

(Өмнөх дугаарын хариу)

6	8	2	4	7	9	5	3	1
3	9	5	6	1	8	2	7	4
7	1	4	5	2	3	9	8	6
8	7	6	2	5	4	3	1	9
1	5	3	8	9	6	4	2	7
4	2	9	1	3	7	8	6	5
9	4	8	7	6	2	1	5	3
2	6	1	3	4	5	7	9	8
5	3	7	9	8	1	6	4	2

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1									
6									
10									
11									
16									

- БОСООГООР:**
- 2. Сондуул
 - 3. ...саар
 - 4. Битгий гэсэн үг
 - 5. Охины хүүхэд
 - 7. Дээл, хувцасны бүснээс дээших
 - 8. Төв аймгийн сум
 - 9. Шекспирийн өвөр тал

- зохиолын алдарт дүр
- 12. Жижиг үслэг мэргэч амьтан
 - 13. Камертон хамтлагийн "Тариаланч" гишүүн (товчилсон нэр)
 - 14. Монголын ах нам
 - 15. Оросын том телевиз

- сумын харьяат МУ-ын гавьяат эмч доктор, профессор
- 6. Үндэсний үлээвэр хөгжмийн зэмсэг
 - 10. Шавь нар нь

- мансууруулах бодис, найраа зэргээрээ хэрэгт хутган шоронд орж байсан мэргэжлийн сүмогийн багш
- 11. Төрийн шагнал ЧЛхамсүрэнгийн алдарт найраглал 16. Олимпын медаль авах бүрэн боломжоо харамсалтай алдсан МУГТ бөх

Өмнөх дугаарын хариу / 04.23

Э	Х	А	Т	А	Н	С	Ү	И	Х	Ү		
Э	А	Р	В	А	Н	Х	А	Н	Г	Л	Э	
Э	Г	Р	О	Ч	Г	Л	Э					
З	А	Л	А	А	Б	И	Ч	А	Т	Л	А	С
О	У	У	У	И	А	Н	А	Э				
П	О	Т	А	Н	И	Н	Д	У	Л	И	А	Н

- ХӨНДЛӨНГӨӨР:**
- 1. Өвөрхангай аймгийн Богд



ЧОН КВАН ЖАН брэнд Солонгос улаан хүн орхоодой

"Чон Кван Жан" улаан хүн орхоодойн онцлог:
Хүн орхоодойг голдуу 4-5 жил ургасныг нь цагаан гэх ба 6 жил ургасан хүн орхоодойг улаан хүн орхоодой гэнэ. Улаан хүн орхоодойд SAPONIN /сапонин/ гэдэг элемент маш ихээр агуулагддаг. Сапонин нь хүний биеийн эд эсийн үүргийг идэвхжүүлэн сэргээж, бактери устгаж, өвчин эсэргүүцэх чадварыг дээшлүүлэн дархлааг сайжруулна. Чон Кван Жан брэндийн хүн орхоодойн бүтээгдэхүүнийг зөвхөн 6 жил тарьж ургуулсан хүн орхоодойгоор хийдгээрээ онцлогтой.

Чанарын гэрчилгээ

Korean ginseng корпораци дараах баталгаа гаргаж байгаа болно. Чон Кван Жан брэндийн улаан хүн орхоодойн бэлдмэл нь Солонгосын эрүүл мэндийн шилдэг 10 бүтээгдэхүүний тэргүүнд тооцогддог ба хамгийн шилдэг бүтээгдэхүүндээ энэхүү чанарын гэрчилгээг олгодог.



OLKHAN

Эрэгтэйчүүдийн бэлдмэл



Эцэж цуцашгүй эрч хүчийг бэлэглэгч "OLKHAN" хүн орхоодой нь биед эрч хүч өгч ядаргааг тайлахаас гадна коллагенийг нэмэгдүүлж биеийн тэсвэр хатуужлыг нэмэгдүүлдэг. Мөн энергийн эх үүсвэр болох өнчин тархины салстаас ялгардаг гармоныг зохицуулж өдгөөрөө давуу талтай.

- Үр дүн**
- Эрчүүдийн бэлгийн чадавхыг сайжруулна.
 - Эцэж цуцашгүй эрч хүчийг бэлэглэнэ.
 - Бие организмд хүч чадал оруулж сэргээнэ.
 - Архи, тамхи, стрессээс үүссэн ядаргааг тайлна.
 - Өөртөө итгэлтэй болж амьдралын идэвх сайжирна.

WOMEN BALANCE BON

Эмэгтэйчүүдийн бэлдмэл



Эмэгтэй хүн нас ахих тусам эмэгтэй гармон багасаж өвчин үүсэх шалтгаан болдог. Эмэгтэйн гармоныг идэвхижүүлж, нөхөн төлжүүлдэг ба цэвэршилтийн үеийн шинж тэмдгийг намдаах онцгой үйлчилгээтэй.

- Үр дүн**
- Эмэгтэйчүүдийн цэвэршилтийн үеийн шинж тэмдгийг намдаана
 - Сарын тэмдгийг тогтворжуулж өвдөлтийг намдаана
 - Эрүүл, эрч хүчтэй гэр бүлийн харьцааг төрүүлнэ
 - 30 аас дээш насны эмэгтэйчүүдэд дутагддаг кальцийг нөхөж яс бэхжүүлнэ.
 - Залуу насны эрч хүч хадгалж баланс тэнцвэржүүлнэ.

EXTRACT LIMITED

Хүн орхоодойн өтгөрүүлсэн ханд



Дээд зэргийн хандалсан бүтээгдэхүүний хувьд хүний биед амархан шингэдэг тул үр дүн нь түргэн илэрдэг. Тамир тэнхээ эрс сульдсан үед хэрэглэвэл бие болоод сэтгэлийн ядаргааг тайлж эрч хүчийг сэргээж өгнө.

- Үр дүн**
- Ядаргаа тайлна.
 - Дархлаа сайжирна.
 - Ой тогтоолт нэмэгдэнэ.
 - Цусны эргэлт идэвхжинэ.
 - Тамир тэнхээ сайжирна.

Утас: 9962-2078, 8805-5943

ЭДИЙН ЗАСАГ

Samsung нугалдаг дэлгэцтэй утсаа хойшлуулаа

Асар их боломжтой загвар технологийн хувьд зах зээлд гарахад бэлэн бус нь илэрлээ.

> 10

F-35-ыг “маллах” Пентагоны зардал өссөөр байна

F-35-ийн судалгаа хөгжүүлэлт, худалдан авах зардал дахиад 22 тэрбум ам.доллараар өсөв.


> 10

“Нийгмийн хариуцлагын тухай ойлголтын зөрүүг арилгана”

Тогтвортой хөгжлийг хангахад 39 их наяд төгрөг шаардлагатай.

> 11

Өнгөрсөн 10-р сараас хойш Хятадын хувьцааны зах зээлийн багтаамж 2.5 их наяд ам.доллараар нэмэгдэж, CSI 300-д бүртгэлтэй 50 компанийн үнэлгээ 50 хувиар өссөн нь хэн нэгний халаасанд ашиг болж орсон гэсэн үг.



Хятад улс дэмжлэгээ танах сургаар хувьцаа нь унав

Bloomberg News

Бээжин дэмжлэгийн бодлогоо үргэлжлүүлэхгүй гэсэн дохио өгсний дараа дэлхийд хамгийн сайн өсөлттэй байгаа хувьцааны зах зээлд эмзэг байдал үүсэв. Даваа гарагт Шанхай, Шеньжэний хөрөнгийн биржийн CSI 300 индекс 2.3 хувь унасан нь сарын хамгийн том алдагдал болж, унасан таван хувьцаанд дээшилсэн ганц хувьцаа харгалзаж байв. Үл хөдлөхийн компаниуд уналтыг тэргүүлсэн бол хэрэглэгчийн зарцуулалтаас хамаардаг салбар удаалсан ба хуучин эдийн засгийн хувьцаа гэгддэг банк, аж үйлдвэрийнх мөн доошилжээ.

Он гарсаар CSI 300 бараг 40 хувь өссөн агаад хөрөнгө оруулагчид эхний улиралд зохицуулагчдаас явуулсан өргөн дэмжлэгийн бодлогоос

ихээхэн хамааралтай байна. Баасан гарагт болсон улс төрийн товчооны хурлаас гаргасан мэдэгдлийг арилжаачид эдийн засаг тогтворжсон тул цаашдаа дэмжлэгийн арга хэмжээ шаардлагагүй хэмээн тайлбарлав. Үүний оронд өрийн хэмжээг багасгах, орон сууцны зах зээл дэх замын худалдаанаас зайлсхийхэд анхаарах төлөвтэй байна.

Шанхайд төвтэй хөрөнгийн менежментийн Hengsheng сангийн менежер Дай Мин “Эдийн засагт бэлэн мөнгө цутгасан идэвхтэй дэмжлэгийн бодлого цуцлагдаж байгааг хүмүүс ерөнхийдөө хүлээн зөвшөөрч байгаа тул хувьцаа үнэлгээ өсөх орон зай хязгаарлагдмал болж байна. Зах зээлд хоёр гурван сар үргэлжилж болзошгүй чанга бодлогын

нөхцөл рүү орлоо” хэмээн дүгнэжээ. Хятадын хувьцааны зах зээл уламжлал ёсоор бэлэн мөнгө ба өдрийн арилжаачдад тулгуурладаг ба эдгээр нь цөөрвөл бэрхшээл тулгарах эрсдэлтэй.

Энэ сарын эхээр эрх баригчид зах зээлд оролцохоо хумина гэсэн мэдээ гарсны дараа хувьцаа доошилж байсан. Хятадын төв банк мөнгөний урсгал бага зэрэг хумигдаж, хөрөнгийг долоо хоногийн зээлд бус урт хугацааны бодлогын хэрэглүүрт зарцуулна гэсэн дохио өгсөн байна. WhiteRock хөрөнгийн менежментийн фирмийн захирал Ван Жихон “Улс төрийн товчоо хөрөнгө оруулагчид хэт урагшаа явсныг мэдэгдлээ” хэмээн тайлбарлав. Тэрээр мэдэгдлийн үг үсэг болон үл хөдлөхөд анхаарах тухай санаа нь хөрөнгө оруулагчдын хөөрлийг намдаах



зорилго агуулсан гэж дүгнэсэн байна.

Шанхайд үл хөдлөхийн компаниудын хувьцаа 3.8 хувиар унаж, гуравдугаар сарын наймнаас хойш хамгийн муу үзүүлэлтэй гарсны дотор Gemdale, Vanke компаниудын хувьцаа зургаагаас дээш хувиа алдав. Экскаватор зэрэг хүнд механизм

үйлдвэрлэгч Sany Heavy Industries-ын хувьцаа сүүлийн гурван жилд хамгийн том нэг өдрийн алдагдал хүлээв. Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэгчдийн хувьцаа доошилсны дотор Gree Electric-ийнх дээд түвшнээс унасан байна.

Гахайн махны үнийн өсөлт инфляцыг хөөрөгдөж байгаа өнөө

үед Хятад улс мэдэгдэхүйц чанга бодлого руу шилжихгүй байх гэж шинжээчид таамаглажээ. Бондын зах зээл сулрах төлөвтэй байгаа тул хувьцаа түүнийг орлож магадгүй юм. Засгийн газрын 10 жилийн бондын өгөөж даваа гарагт 3.41 хувь болж өссөн нь таван сарын дээд түвшин рүү ойртжээ. Өнгөрсөн 10-р сараас хойш Хятадын хувьцааны зах зээлийн багтаамж 2.5 их наяд ам.доллараар нэмэгдэж, CSI 300-д бүртгэлтэй 50 компанийн үнэлгээ 50 хувиар өссөн нь хэн нэгний халаасанд ашиг болж орсон гэсэн үг. Гэхдээ Бээжин өнгөрсөн онд хэрэгжүүлсэн онцгой дэмжлэгийн бодлогоо халж, эдийн засгаа дэмжих онилсон арга хэмжээ рүү шилжиж байна гэж шинжээчид үзэж байна.

Хонконгийн үл хөдлөхийн эзэн хүүдээ \$400 саяа үлдээсэнгүй

Шауна Кван

Үл хөдлөх хөрөнгө асар үнэтэй Хонконгийн хамгийн том үл хөдлөхийн агентлагийг залгамжлагч хувьдаа байргүй гэнэ. Үүгээр зогсохгүй түүний эцэг Centaline Group компани дахь 400 сая орчим ам.доллараар үнэлэгдэх эзэмшлээ хүүдээ өвлүүлэхгүй арав гаруй жилийн өмнө буяны байгууллагад хандивласан ажээ. Гэвч Алекс Ши Хонконгийн баячуудын үр удам шиг их өв залгамжилж аваагүйдээ гонсойсон зүйл алга.

30 настай ноён Ши аав нь гурван хүүхдэд баялгаа үлдээгээгүй талаар “Би хувьдаа үүнийг хүлээн зөвшөөрнө. Биднийг бүр бага байхад тэр бидэнд боломж байхгүйг хэлдэг байсан. Аав маань хэтэрхий тансаг амьдрах нь сайн зүйл биш. Хэрэв та нар алхам алхмаар хуримтлуулбал илүү эрдэнэс цуглуулна гэж хэлдэг байсан” хэмээн өгүүлжээ.

Оны эхэнд Ши Хонконгийн үл хөдлөхийн хэлцлийн таваас хоёрыг гүйцэтгэдэг Centaline компанийн удирдах зөвлөлийн дэд даргаар томилогдсон. Тэрээр өөрийн эцэг 70 настай Вин Чин Шиг удахгүй чөлөөнд гарахад зөвлөлийн дарга болох төлөвтэй байгаа. 1978 онд байгуулагдсан компанийн хувьд хүнд жил өнгөрсний дараа хүү Ши дээд албанд ирэх бололтой. Эдний зуучлалын орлого 2018 онд ганц хувь өсөж, 2.4 тэрбум ам.доллар болсон бол цэвэр ашиг нь 52 хувиар буурчээ. Энэ нь Хонконгийн үл хөдлөхийн зах зээл суларч, эх газрын өрсөлдөөн нэмэгдсэнээс шалтгаалсан юм.

Харин саяхнаас арлын зах зээл сэргэж буй тул ноён Ши компания шинэчлэхээр төлөвлөв. Тэрээр 2017 оноос

нэвтрүүлсэн байшингийн виртуал танилцуулгыг хянахын сацуу борлуулалт ба түрээсийн гэрээ хийх блокчейн платформын удирдлагад оролцдог.

Тус компани өдөртөө сая саяын өртөгтэй гэрээнд зуучилдаг авч зөөлөн дуутай, даруухан Ши ердөө л цалингаа авдаг. Түүний эцгийн хөрөнгөө хандивласан сан Хятадын хөдөө нутагт ядуурлыг бууруулах зорилгоор ажилладаг агаад дэд бүтэц барихаас эхлээд ядуу хүүхдийн боловсролыг дэмжихэд хүчин зүтгэдэг аж. Ши ярихдаа санхүүгийн салбарт ажилладаг найзууд нь түүнээс илүү мөнгө олдгийг хүлээн зөвшөөрөв.

Тэрээр өөрийгөө Лондоны эдийн засаг, улс төрийн ухааны сургуулийг төгссөн, Хонконгийн дундаж иргэн гэж үздэг. Саятнх гэж хэлэхээргүй жижигхэн оффисоо элдвээр чимэглэх дургүй агаад ууланд авирах, бадминтон тоглох дуртай нэгэн. Энгийн нөхцөлд өссөн нь түүнийг даруу байхад сургажээ. Аав нь баячуудын хувийн сургуульд оруулалгүй улсын төсвийн жирийн сургуульд сургасан тул багаасаа мөнгийг ядууст зориулах ёстой гэсэн гүн ухаан шингэсэн юм.

Түүний үеийнхэндээ өгдөг зөвлөгөө нь “Бодитой бай” гэдэг үг. Ши хоёр унтлагын өрөөтэй байр худалдан авахаар төлөвлөж байгаа нь тус компанийн зуучилдаг олон саяын үнэтэй тансаг сууцнаас эрс ялгаатай. Тэрээр “Анхны байр маань миний хүссэнээс даруухан байж магадгүй. Гэхдээ үл хөдлөхийн шатан дээр гишгэх тул аажмаар өсөх боломжтой” хэмээн өгүүлсэн юм.

Хятадад STARBUCKS-ТАЙ ӨРСӨЛДӨГЧ АНУ-Д IPO ХИЙНЭ

Юэки Ян
Хятадын өсөн нэмэгдэж буй кофены зах зээлд Starbucks ноёлж байгаа хэдий ч дотоодын Luckin Coffee компани өрсөлдөгчөөр тодорч, хувьцаагаа АНУ-ын анхдагч зах зээлд гаргаа зарлав. Бээжинд төвтэй тус сүлжээ LK нэрийн дор Nasdaq-т хувьцаагаа байршуулахаар төлөвлөсөн байна. Эдний IPO-гоор 300 сая орчим ам.доллар босгох таамаг бий. Luckin-ы зах зээлийн үнэлгээ 2.9 тэрбум ам.доллар гэж тооцож буй үед тус стартап-п өнгөрсөн долоо хоногт BlackRock болон бусад хөрөнгө оруулагчдаас 150 сая ам.доллар татсан байна. Эднийх 2017 онд байгуулагдсанаас хойш 28 хотод 2370 кафе нээжээ.

КИМ ЖОН УН, ВЛАДИМИР ПУТИНТЭЙ УУЛЗАНА

Associated Press
Хойд Солонгосын удирдагч Ким Жон Ун удахгүй ОХУ-д айлчилж, Ерөнхийлөгч Владимир Путинтэй уулзана гэсэн мэдээллийг Пхеньян мягмар гарагт нотлов. Трамптай хийсэн уулзалт амжилтгүй төгсөж, Хойд Солонгос саяхан пуужингийн туршилт хийсний дараа эгзэгтэй цаг үед энэхүү дээд хэмжээний уулзалт болох гэж байна. Умардын мэдээллийн агентлаг “Ким удахгүй ОХУ-д айлчилж, Путинтэй уулзана” гэсэн товчхон мэдээ цацжээ. Уулзалтын огноог зарлаагүй бөгөөд их удирдагч хуягт галт тэргээрээ явах уу, нисэх үү гэдэг нь ч тодорхойгүй байна. Гэхдээ хоёр тал Хойд Солонгост ойролцоо Владивосток хотод уулзаж магадгүй гэсэн чиглэл байгаа аж.

АНУ-ЫН ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ ДООШИЛЖЭЭ

Прашант Гопал
Америкийн хурц өрсөлдөөнтэй үл хөдлөхийн зах зээлд худалдан авагчдын хүссэн боломж бий болов. Өөрөөр хэлбэл, бараа буюу байр элбэгшсэн гэсэн үг. Гэтэл борлуулалт өсөх биш буурсан байна. Жишээ нь Солт Лейк хотод байрны захиалга өмнөх оноос 53 хувь, худалдан авах хэлцлийн тоо 21 хувиар унажээ. Шинжээчид үүнд моргейжийн өртөг өссөн явдал буруутай гэж үзэж байна. Өнгөрсөн онд моргейжийн хүү өсөж, орон сууц худалдан авах өртөг дээшилсний улмаас иргэд хойш суух болжээ. Өндөр үнэтэй бүсэд хүнд туссан Трампын татварын бодлого үүнд давхар нөлөөлсөн авч энэ онд зээлийн хүү буурвал байдал эргэж магадгүй юм.

Натри ихтэй хоол америкчуудад үнэхээр халтай

Александр Танзи

Хоолны дэглэм эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн шинэ судалгаанаас үзэхэд АНУ-д натри ихтэй хүнс зуун мянган хүн тутамд 33 үхлийн шалтгаан болдог гэсэн тооцоо гарчээ. Харин мах илүү хэрэглэдэг хоолны дэглэмтэй хүмүүст хавьгүй бага буюу зуун мянгад хоёр хүрэхгүй үхлийн тохиолдол гардаг гэж дүгнэсэн байна. Гэхдээ хотдогийг хоолны дэглэмд ашиглах нь сөрөг нөлөө ихтэй гэж үзжээ. АНУ-ын 1990 оноос хойших насаар ангилсан 15 үхлийн шалтгаан дотроос натрийн хэрэглээ хамгийн

өндөр эрсдэл дагуулсныг тогтоожээ. Вашингтоны их сургуулийн Эрүүл мэндийн хэмжилт ба үнэлгээний хүрээлэнгийн профессор Ашкан Афшин “Сүүлийн жилүүдэд эрүүл

хооллолын хэлэлцүүлэгт натри, сахар болон өөх тос гол байр эзэлж байсан. Үнэлгээнээс үзэхэд үхэлд хүргэх хамгийн өндөр эрсдэлтэй хүнсэнд натрийн агууламж их, бүхэл үр, жимс, самар, үр тариа ба ногооны хэмжээ бага байдаг” хэмээн өгүүлэв. АНУ-ын хувьд нэг нааштай

үзүүлэлт нь ханасан бус тосны хүчлийн хэмжээгээр хамгийн бага гурван орны тоонд багтсан байна. Түүнчлэн бүхэл үрийн хэрэглээгээр дэлхийн 195 улсаас 38-д нь жагсжээ.

2017 онд зуун мянган хүн тутамд 45.7 нас баралт бүхэл үрийн дутагдлаас шалтгаалсан гэж үзсэн. Доктор Афшины ярьснаар “Дэлхий даяар үхлийн шалтгаан болдог хамгийн эрсдэлтэй 10 хүнсний хүчин зүйл нь хоол эрүүл бус хүнс их идсэнээс бус эрүүл хүнс бага хэрэглэсэнээс болдог” аж. Хүнснээс шалтгаалсан үхлийн тоо АНУ-д зуун мянган хүн тутамд 170.7 байгаа нь 47 дугаар байрт орж, 1990 оны зэрэглэлээс зургаан шат ахисан байна. Гэхдээ үнэлгээ хийхэд ашигласан 15 шалгуурын “боловсруулсан махны орц ихтэй” гэсэн үзүүлэлтээр сүүлийн байр эзэлжээ.



Эдийн засаг

АНУ-д 65-аас дээш насны ахмадуудын 20 хувь нь ажиллахаас аргагүй нөхцөлд амьдарч байна.

Айл гэрт аль нэг нь ажиллаж мөнгө олдог үе өнгөрсөн зуунаар төгсгөл болсончлон АНУ-ын ахмад үеийнхэн ч адилхан учир шалтгаанаар тэтгэвэрт гарахаа тэвчихээс аргагүйд хүрлээ. Шалтгаан ердөө л амьдралд мөнгө хүрэхээ больсон явдал. Нийгмийн хамгааллын эмзэг тогтолцоо, хомс тарчиг тэтгэврийн хадгаламж, үнэ нь тэнгэрт хадсан эрүүлийг хамгаалахын зардал нийлэхээрээ ажиллах хүчийг тун аюултай нөхцөлд оруулж байна.

Нийт ажиллах хүчинд тэтгэврийн насныхны эзэлж буй хувь хэмжээ сүүлийн 57 жилд анх удаа 20 хувиас давсныг хөрөнгө оруулалт, санхүүгийн менежментийн Uniter Income компанийн шинэ тайлан харуулав.

Ажиллаж байгаа болон ажил хайж буй 65-аас дээш насны хүмүүсийн хувь хэмжээ 1985 оны эхээр нийт ажиллах хүчний 10 хувийг эзэлж байсан бол энэ оны хоёрдугаар сарын байдлаар хоёр дахин ихсээд байна. Ялангуяа дээд боловсролтой ахмад насны ажиллах хүчний хэмжээ суга өсөв. Доод тал нь бакалаврын зэрэг бүхий 65-аас дээш насны ажилтай хүмүүсийн эзлэх хувь хэмжээ 1985 онд 25 хувьтай байсан бол эдүгээ даруй 53 хувь боллоо.

Дээд боловсролтой ахмад ажилтны инфляц тооцсон орлогын дундаж 1985 онд 48 мянган ам.доллар байсан бол 2018 оны байдлаар 63 хувь өсөж 78 мянган ам.долларт хүрэв. Гэтэл 65-аас доош насны америк ажилчдын дундаж орлого мөн хугацаанд ердөө 38 хувиар өсөж 55 мянган ам.доллар болжээ. United Income-ын тооцоогоо АНУ-ын Ажиллах Хүчний Статистикийн Хорооноос (BLS) саяхан нийтэлсэн тоо баримтад тулгуурлан гаргасан байна.

Нөгөө талаар ажиллаж орлого олох нэн шаардлагатай болон ажил хийх чадвартай ахмад насны хүмүүсийн харьцаа алдагдсаныг United Income-ын дэд ерөнхийлөгч Элизабет Келли анхааруулав. Обамгийн засаг захиргааны үед Элизабет Келли Цагаан ордны Үндэсний Эдийн Засгийн Зөвлөлд ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж байсан юм.

“Ажилласаар байгаа хэсэг нь боловсрол илүү, боломж сайтай, эрүүл чийрэг хүмүүс. Гэтэл

АНУ-ын Индиана муж улсын Сеймур дахь дизель хөдөлгүүр угсрах үйлдвэрийн ажилчин эд анги угсарч байгаа нь.



BMM©

Ажиллаж буй ахмадуудын тоо АНУ-д хоёр дахин өслөө


боловсрол тааруу, ажилчин ангид хамаарагдах хэсэг л чухамдаа ажиллахгүй бол амьдрах аргагүйдээ тулсан бололтой” хэмээн Келли тайлбарлав.

Baby Boomers буюу 1946-1964 оны хооронд хорвоод мэндэлсэн, өнөөгийн тэтгэврийн насныханд лавтайяа 2024 он хүртэлх АНУ-ын ажиллах хүчний өсөлтийн томоохон хувь оногдох төлөвтэйг BLS-ын тайлан нотолж байна. Цаашид “2024 он гэхэд бэйби бумерүүд 60-аас 78 настай болно” хэмээн BLS-ын тайланд анхааруулжээ. “Гэтэл энэ хүмүүсийн зарим нь нийгмийн халамжид хамрагдах болчихоод байхад ажлаа хийсээр байх

төлөвтэй”.

Математик тооцоо хийж үзвэл ахмадуудын харьцангуй боломжтой хэсгийнхний байдал хүртэл хүнд. Нийгмийн Судалгааны Шинэ Сургуулийн (New School of Social Research) эдийн засгийн ухааны профессор Тереза Гиллардучигийн тооцоогоор нийгмийн даатгалаас олгодог тэтгэмж нь ахмадуудын тэтгэвэрт гарахаас өмнө олдог байсан орлогын дундаж 40 хувь болдог. Гэтэл гавьяаны амралтаа эдлэх хүмүүс ажиллахгүйгээр амьдрах гэвэл ажиллах байсан үеийнхээ орлогын ядаж 80 хувийг олдог байх шаардлагатай байгаа юм.

АНУ-ын ажиллах хүчинд 65-аас дээш насны хүмүүсийн эзлэх хувь хэмжээ



Хүн амын 50 хувийг бүрдүүлж буй үнэмлэхүй бага орлоготой хэсэг жилдээ 40 мянган ам.доллар хүрэхгүй мөнгө олдог, тэтгэврийн хадгаламж байхгүй. Тэгвэл дунд түвшнийхэн буюу хүн амын 40 хувийг эзэлж буй иргэд жилдээ 40 мянгаас 115 мянган ам.долларын орлого олж, дундаж 60 мянган ам.долларыг хадгаламжид зориулдаг гэсэн тооцоог Гиллардучи хийжээ.

Харин хүн амын 10 хувийг бүрдүүлж буй манлай хэсгийнхэн жилдээ 115 мянган ам.доллараас дээш орлого олж, дундаж 200 мянган ам.долларын хадгаламжтай байгаа юм.



Асар их боломжтой загвар технологийн хувьд зах зээлд гарахад бэлэн бус нь илэрлээ.

Samsung нугалдаг дэлгэцтэй утсаа хойшлууллаа

Марк Гурман

Samsung Electronics эвхээд ухаалаг утас, дэлгэцд жижиг таблет болдог 1,980 ам.долларын үнэтэй Galaxy Fold загварыг зах зээлд гаргах товоо хойшлуулснаа даваа гарагт зарлав. Bloomberg News тойм бэлтгэхээр зээлсэн загвар туршилтын хоёр дахь хоногтоо ажиллахаа больсон. Сольж өгсөн загвар ч гажигтай байсан нь Өмнөд Солонгосын технологийн аварга товоо хойшлуулсан шалтгааны тайлбар болж байна.

Хэдийгээр Fold-ын дэлгэцийн гэмтэл олны анхаарлыг голлон татаж байгаа ч өөр бусад асуудал бас бий. Fold нь ухаалаг утас гэхэд өөтэй. Таблет гэхэд бас л дутагдалтай. Хоёр өөр төрлийн юмны шинжийг давхар хадгалсан Galaxy Fold нь мобайл тооцооллын ирээдүйд нэг хэсэгт шуугиан дэгдээж мэдэх ч олон жил үргэлжлэхгүй бололтой.

Fold загвар тоймчдын гар

дээр анх дөрөвдүгээр сарын 15-нд ирсэн. Эхний сэтгэгдэл лут байлаа. Apple Inc, Google зэрэг үйлдвэрлэгчдийн тэгш өнцөгт гялгар хар загвараар хахсан ертөнцөд ядаж Samsung арай өөр юм оруулж ирлээ.

Гэвч удсан ч үгүй Fold олон юманд буулт хийсэн загвар болж таарав. Ухаалаг утсыг эвхээстэй нь хэрэглэхээр нэг л эв хавгүй, зузаан - бараг хоёр смартфон давхарлачихсан юм шиг. Эвхээстэй үеийн 4.3 инчийн дэлгэц нь утасны дуудлага хийх, хүлээн авахад тохиромж муутай. Товч мессеж бичихээс бусад хэрэглээнд дэлгэц нь хэтэрхий нарийхан. Том дэлгэцтэй бусад ухаалаг утастай харьцуулахад нүүрэн дэлгэц нь хачин, дээд доод ирмэг нь зузаан. Харин нүүрэн шил нь бусад ухаалаг утасныхтай адил бөх юм уу даа гэж санагдаж байв.

Гаджетийг дэлгэчихвэл том, хурц, өнгөлөг дэлгэцтэй болно.

Гэтэл энэхүү том дэлгэцэнд ноцтой гажиг илэрлээ. Дотор талын дэлгэц нь шинэ авсан утас, таблет, телевизийг хайрцагас нь гаргахад байж байдаг дэлгэц хамгаалах нимгэн хуванцар хальс шиг хальстай юм. Энэхүү хамгаалалтын хальс зүүн захиасаа хөндийрч эхэлсэн тул бодсон ч юмгүй хуулаад авчихлаа. Гэтэл хальсыг хуулж авснаас хойш удалгүй дэлгэцийн өнгө шууд муудаж эхлэв. Samsung компани энэхүү хальсыг хэвээр нь үлдээх ёстойг тойм бэлдэгчдэд хэлж өгөөгүй, хайрцаг саван дээр нь ч авч болохгүй гэсэн анхааруулга байгаагүй.

Ганц хоноод нугалдаг дэлгэц зүүн захиасаа ажиллагаагүй боллоо. Шөнө нь дэлгэцийн баруун хагасын дөрөвний гурав нь бүрмөсөн харлав. Дараагийн өглөө гэхэд нугалдаг дэлгэц бүрмөсөн “үхэв”. Бас дэлгэцийн нугалааны дээд ирмэг жижгэвтэр цуурсан. Энэ цууралт ч дэлгэц ажиллаагүй

болоход нөлөөлсөн биз. Гэхдээ л 1,980 ам.долларын утас ганц нимгэн хальснаас болоод бүрмөсөн ажиллахаа болино гэж баймааргүй.

Хэд хэдэн тоймчийн гомдлын дараа Samsung компани хэмхэрхий Fold-ыг эргүүлэн авч шинээр сольж өгсөн юм. Шинээр сольж өгсөн загварт ч дэлгэц хамгаалах хальстай холбоотой анхааруулга байсангүй. Гэхдээ хэрэглэгчдэд нийлүүлэх загварт ийм анхааруулга хавсаргана гэдгээ Samsung өнгөрсөн долоо хоногт мэдэгдсэн.

Хамгаалалтын хальсыг хуулаагүй хоёр дахь Fold эхний загварын эмгэнэлт хувь тавиланг давтсангүй. Гэхдээ сольж өгсөн загварыг хайрцагас нь гаргахад хамгаалалтын хальсан дээр өчүүхэн хонхорхой ч юм шиг нүх зүүн хагаст нь байв. Дээр нь хамгаалалтын хальсны ирмэг, дэлгэцийн хоорондох мэдэгдэхүйц завсраар өрөө тасалгааны нарийн тоос шороо орох эрсдэлтэй юм. Хоёр хоног хэвийн ажилласныхаа дараа дэлгэцийн хамгаалалтын хальс ирмэгээсээ цайж эхлэв. Дэлгэцнээ ч өөр бусад жижиг дефект үүсэж эхэлсэн нь Fold хэрэглээний ая даахааргүй эд болохыг гэрчилж өглөө. Дээр нь Fold-ын хэт хялгар дэлгэц зарим нөхцөлд харахад түвэг учруулж байлаа. Дэлгэц зэрэг техник хангамжийн тал нь төгс болж чадаагүй ч программ хангамжийн тал нь өөгүй бололтой. Ихэнх программ жижиг дэлгэцээс нугалдаг том дэлгэцнээ ямар ч түвэггүй шилжиж байна.

Бараг долоо хоног Galaxy Fold-ыг хэрэглэж үзсэний эцэст Samsung-ын шинэ загвар нь эцсийн бэлэн бүтээгдэхүүн биш, концепт загвар биш үү гэсэн бодол төрөв.

F-35-ыг “маллах” Пентагоны зардал өссөөр байна

Дэлхийд хамгийн үрэлгэн зэвсэглэлийн хөтөлбөр – Lockheed Martin Corp-ын F-35 сөнөөгч онгоц үнэтэй дээрээ үнэтэй болсоор.

F-35 онгоцны судалгаа хөгжүүлэлт, худалдан авах үнэ инфляцыг харгалзсан одоогийн ханшаар даруй 22 тэрбум ам.доллараар нэмэгдээд байгааг Пентагоны голлох төслүүдийн жил тутмын зардлын сүүлийн шинэ тооцоо харуулав. Сөнөөгч онгоцны паркийг 60 гаруй жил ажиллуулж, дэмжих зардал

428.4 тэрбум ам.долларт хүрсэн нь ажиллах хүч, материалын зардал хэтэрч, хойшлогдсоноос шалтгаалаагүйг Батлан Хамгаалах Яамнаас өнгөрсөн долоо хоногт Конгресст илгээсэн тайланд анхааруулжээ. “Block 4” томьёолсон нэртэй ээлжит сайжруулалтын улмаас зардал дахиад өсөж байгааг уг тайланд тайлбарласан юм.



Зардал байнга өсөж хүндрэл учруулж буйтай холбогдуулан АНУ-ын Батлан Хамгаалах Яам 2021 он хүртэлх хугацаанд авахаар төлөвлөсөн F-35 онгоцны тоог 17-гоор цөөрүүлж 81 болгосноо тайланд дурджээ.

Пентагон нийт 2,456 ширхэг F-35 сөнөөгч онгоц Lockheed Martin-аас худалдаж авах төлөвлөгөөтэй. Үүнээс 1,763 нь Агаарын Цэргийн Хүчний, 420 нь Тэнгисийн Явган Цэргийн, 273 нь Тэнгисийн Цэргийн Хүчний зориулалттай загвар байх юм. Lockheed Martin мөн АНУ-ын холбоотон улсуудын зэвсэгт хүчинд 700 гаруй F-35 нийлүүлнэ.

Урьд нь 406.2 тэрбум ам.доллараар тооцсон сөнөөгч онгоц эзэмших зардал 5.5 хувь өсөж

Эдийн засаг

“Нийгмийн хариуцлагын тухай ойлголтын зөрүүг арилгана”

Төрийн зүгээс нийгмийн хариуцлага сайтай компаниудыг татвар, дэд бүтэц, бодлогоор дэмжинэ.



С.Батсайхан / ЗГМФ

корпорациуд төрөн гарах боломж бий.

Ойрын тав, арван жилдээ эерэгээр өөрчлөгдөх итгэл байна

–Нийгмийн хариуцлагыг хуульчилна гэж та хэлсэн. Үүнийг тодруулахгүй юу?

–Манай зарим томоохон хувийн хэвшлийн байгууллага өөрийн гэсэн нийгмийн хариуцлагын бодлогынхоо хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Харин орон нутагт ойлголтын зөрүү бий. Тухайлбал, сумын наадамд хандив авах, бүтээн байгуулалтад мөнгө татах гэсэн ойлголтоор нийгмийн хариуцлагыг үнэлдэг болсон нь зайлшгүй хуульчлах шаардлагатайг харуулж байна. Олон улсад зөвшөөрөгдсөн нийгмийн хариуцлага гэдэг ойлголт хугацаандаа татвараа төлдөг, ажилчдынхаа амьдралд хүрэлцэхүйц цалин олгодог, байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарладаг гэх мэт үзүүлэлт багтдаг. Ийм компани манайд олон, цаашдаа ч төрөн гарах байх.

Төрийн зүгээс нийгмийн хариуцлага сайтай компаниудыг татвар, дэд бүтэц, бодлогоор дэмжинэ. Харин дэмжлэг авсан компаниуд эргээд жижиг дунд үйлдвэрлэгч, бичил бизнесүүдийг дэмжиж, иргэдийг ажлын байраар хангах маягаар системээрээ урагшилж тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах юм.

–Олон улсын туршлага юу байдаг вэ?

–Герман улсад төр хувийн хэвшлийн түншлэлийг сонгодог утгаар нь хэрэгжүүлсэн. Тиймээс Конрад Аденауэрын сантай хамтарч, тэдний туршлагыг судалж байна. Ганц Герман ч гэлтгүй, Азийн улсуудад, ялангуяа Япон, БНСУ зэрэг улсад тогтсон төр хувийн хэвшлийн харилцааны эрүүл хувилбарыг бий болгохоор ажиллаж байна.

–Хуулиудын төсөлд хариуцлагын систем тусгасан уу?

–Хэлэлцүүлгийн шатанд ямар асуудал хөндөгдөхийг харья. Бизнесийн эрүүл орчныг бүрдүүлэх, зөв механизм тогтоох нь л гол зорилго гэдгийг төр, хувийн хэвшил ч ойлгож, үр дүнг хүлээж байна. Тиймээс хариуцлагын системийг тусгана гэхээсээ илүүтэй малгай хуулиудаар тогтвортой орчин бүрдүүлэх нь чухал юм. [ЗГМ]

Тогтвортой хөгжлийг хангахад 39 их наяд төгрөг шаардлагатай

Э.Батцэцэг
ЗГМ

Төр бизнесийнхэн хамтран “Тогтвортой хөгжлийг хангахад хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт үндэсний форумыг энэ сарын 26-нд зохион байгуулна. Уг чуулганаар хэлэлцэх үндсэн асуудлыг боловсруулсан Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхантай ярилцлаа.

–“Тогтвортой хөгжлийг хангахад хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт чуулган зохион байгуулах шаардлага нь юу юм бол?

–2015 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганаар “Тогтвортой хөгжлийн зорилт 2030” бодлогын баримт бичгийг баталсан. Эндээс үүдэн Монгол Улс урт хугацааны бодлогоо тодорхойлсон. Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталж, Үндэсний хөгжлийн газарт (ҮХГ) энэхүү хуулийн хүрээнд Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүргийг өгсөн юм. Гэхдээ ганц ҮХГ биш, УИХ, Засгийн газар, бүх яам, агентлаг, орон нутгийн удирдах байгууллагууд хамтран ажиллах ёстой.

–Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд хэдий хэрийн санхүүжилт шаардлагатай байна. Үүнийг хаанаас бүрдүүлэх вэ?

–Монгол Улсын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийг хангах зорилтуудыг хэрэгжүүлэхэд ойролцоогоор нийт 39 их наяд төгрөг шаардлагатай гэсэн тооцоо бий. Үүнийг төр засаг дангаараа гаргах боломжгүй. Тиймээс хувийн хэвшлийн түлхүү оролцуулах бодлого барих юм. НҮБ-ын судалгаагаар дэлхий нийтээр тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо 70-80 хувьтай байна гэж тодорхойлсон.

–Хэлэлцүүлэгт дэвшүүлэх гол санаа юу вэ?

–2018 оны хоёрдугаар сард Үндэсний хөгжлийн газраас Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нэгдүгээр үе шатыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг болох “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” гэж гаргасан. Үүнд хувийн хэвшлийн түлхүү оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс баялаг бүтээгчдийг дэмжих цогц бодлого, багц хуулийг боловсруулж хэлэлцүүлэгт бэлдэж байна. Компанийн нийгмийн хариуцлагыг тодорхой болгох, төр хувийн хэвшлийн түншлэлийг ямар хэлбэрээр зохицуулах, мөн мэргэжлийн холбоодын эрх зүйн байдлыг тодорхойлох зэрэг асуудлыг багтаасан цогц хуулийн төсөл боловсруулж, чуулганд оролцогчдоос санал авахаар бэлдэж байна. ҮХГ-аас суурь судалгаа хийж, одоо хувийн хэвшлийнхний саналыг тусгах гэж байгаагаараа ач холбогдолтой форум юм.

–Эдгээр хуулийн төслийг ямар хугацаанд бэлдсэн бэ?

–Жил хагасын өмнөөс судалж

эхэлсэн. Ажлын хэсэг байнгын ажиллагаатай. Энэхүү суурь хуулиудын хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулахад УИХ, Засгийн газартай нягт хамтран ажиллаж байна. Ц.Гарамжав гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бодлогын төслүүдийг улам сайжруулахаар оролцож ирсэн.

● **Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо 70-80 хувьтай байна гэж тодорхойлсон.**

● **Хувийн хэвшлийнхний өмнө тулгардаг асуудлуудаа танхимаар дамжуулж зөвлөлдөх хороонд хэлэлцүүлсээр ирсэн.**

● **Монголд төр, хувийн хэвшлийн түншлэл тодорхойгүй учраас бизнесмэнүүд нь үйл ажиллагаагаа хамгаалахын тулд улс төрд орох үзэгдэл хэвийн боллоо.**

–Суурь судалгаанд хувийн хэвшлийнхний зүгээс ямар мэдээлэл ирж байв?

–Засгийн газарт “Хөрөнгө оруулагчдын үндэсний зөвлөл” гэж бий. Даргаар нь ЗГХЭГ-ын дарга, ҮХГ уг зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэдэг. Харин энэ зөвлөлийн дэргэд “Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо” гэж байдаг юм. Даргаар нь ҮХГ-ын дарга миний

бие, дэд даргаар нь МХАУТ-ын ерөнхийлөгч ажиллаж, эрх үүргээ тавь тавин хувиар хангаж ирсэн тул асуудлыг хоёр талаас тэгш зөвлөлдөх механизмыг тогтоосон л доо. Хувийн хэвшлийнхний өмнө тулгардаг асуудлуудаа танхимаар дамжуулж зөвлөлдөх хороонд хэлэлцүүлсээр ирсэн.

Зорилтуудын нэн тэргүүнд ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах асуудал байдаг. Үүнийг хувийн хэвшлээ дэмжих замаар хангахын тулд бизнесийн эрүүл орчныг бүрдүүлж өгөх шаардлага зүй ёсоор тулгарч байгааг тодорхойлсон.

–Монголд нийгмийн хариуцлага хэрэгжүүлэх томоохон компани цөөхөн байдаг. Тэгш оролцоотой байлгахын тулд хууль зохицуулалт хийх үү?

–Үндэстэн дамнасан том корпорациудыг бий болгох асуудал чухал л даа. Тэднийг дагаж жижиг дунд үйлдвэрлэгчид, гарааны бизнес эрхэлж буй иргэд хөгжиж, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг өсгөдөг. Түүнчлэн улс орны хэмжээний томоохон асуудлуудыг үндэстэн дамнасан корпорациуд шийдэхэд дэм болж ирсэн жишээ олон улсад байна. Монголд төр, хувийн хэвшлийн түншлэл тодорхойгүй учраас бизнесмэнүүд нь үйл ажиллагаагаа хамгаалахын тулд улс төрд орох үзэгдэл хэвийн боллоо. Ингэж өөрсдөө төрийн албан хаагч болчихоод компаниа чирч явахыг эрмэлздэг нь нууц биш. Үүнийг зохицуулж, зөв механизм тогтоохоор ажиллаж байна. Гэхдээ богино хугацаанд үр дүн нь гарахгүй л дээ. Хууль эрх зүйн орчныг нь тодорхой болгож өгвөл ойрын тав, арван жилдээ зөрлөгөө өөрчлөгдөх итгэл байна. Ингэж эрүүлжсэн бизнесийн орчинд үндэстэн дамнасан том

ДААТГАЛ

“Бодь даатгал” IPO гаргана



ЗГМФ

Г.Илч
ЗГМ

Монгол Улсын даатгалын салбарын “Бодь даатгал” компани анхдагч зах зээлд хувьцаагаа арилжиж, нээлттэй компани болох гэж байна. Тус компанийн хувьцааны андеррайтераар “Бидисек” ажиллаж байгаа ба энэ онд багтаан IPO-оо гаргана гэж эх сурвалж мэдээллээ. Ийнхүү “Бодь даатгал” нээлттэй хувьцаат компани болсноор тус салбараас хөрөнгийн зах зээлд хөл тавьж буй гурав дахь тоглогч болох юм.

Энэ он гарсаар хоёр компани анхдагч зах зээлд хувьцаагаа арилжиж, нийт 15 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан. Мөн хүнсний салбарын “Монос хүнс” компани хувьцааны анхдагч зах зээлийн захиалгаа даваа гарагаас эхлүүлсэн бөгөөд тавдугаар сарын гурван хүртэл үргэлжлэх аж. Тус компани хувьцааныхаа 30 хувь буюу 122.6 сая хувьцааг, нэг бүрийг нь 70 төгрөгөөр санал болгож буй. “Бодь даатгал” 8.6 орчим тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр зорьж байна. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.04.24

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Хуванцар усан сан /8тн багтаамжтай/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2019-156

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **хуванцар усан сан /8тн багтаамжтай/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2017, 2018/ тус бүр тухайн барааны төсөвт өртөгөөс дээш байх.
Тендерийн хамт 1,800,000 /нэг сая найман зуун мянган/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 08 дугаар сарын 6-ны өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минутас өмнө** цахим системээр тендерийн материал аирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 10 цаг 30 минут-аас** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.
Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

41.5

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржийн даваа гарагийн арилжаагаар 22 хувьцаат компанийн 63.8 сая төгрөгийн 615 мянган ширхэг хувьцаа арилжжээ.

» ХУВЬЦАА

5

Хувь. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Айтүүлс” компанийн хувьцааны ханш 5.6 хувиар чангарч, ханшийн өсөлтөөрөө хөрөнгийн биржийн арилжааг тэргүүлээ. Мөн “Шивээ Овоо” компанийн хувьцааны ханш 3.7 хувиар чангарч, өсөлтийг удааллаа. Харин “Могойн гол” компанийн үнэт цаасны ханш таван хувиар уруудсан нь огцом уналтад тооцогдож байна.

» ТҮҮХИЙ ЭД

0.6

Хувь. Олон улсын зах зээлд Brent төрлийн газрын тосны ханш 0.6 хувиар өсөж, 74.5 ам.долларт тэнцэв. Ингэснээр зургаан сарын дээд цэгт хүрлээ.

» УУЛ УУРХАЙ

1.8

Хувь. Лондоны металлын биржид тонн цайрын хүдрийн ханш 1.8 хувиар өсөж, 2767 ам.долларт хүрлээ.

» ИНДЕКС

0.2

Bloomberg-ээс тооцдог түүхий эдийн жишиг индекс 0.2 хувиар өслөө. Энэ нь сүүлийн саруудад ажиглагдаагүй огцом өсөлт болов.

» БОНД

2.5

Хувь. АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 2.5 хувиар буурсан бол Германы ижил төрлийн үнэт цаасны ханш 0.05 хувиар өслөө.

» САНХҮҮ

0.1

Хувь. Ам.доллартай харьцах иенийн ханш 0.1 хувиар чангарч, 111.85 нэгжид хүрлээ. Харин фунттай харьцах ам.долларын ханш 0.1 хувиар суларч, 1.3067 нэгжтэй тэнцэв.

» САНХҮҮ

0.1

Хувь. Bloomberg-ээс тооцдог ам.долларын спот индекс 0.1 хувиар өслөө. Харин евротой харьцах ам.долларын ханш 0.1 хувиар суларч, 1.1299 нэгжтэй тэнцлээ.

ВАЛҮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,638.33
Евро	2,968.25
Японы иен	23.58
ОХУ-ын рубль	41.36
БНХАУ-ын юань	392.68
БНСУ-ын вон	2.31

Уул уурхай

ОХУ-ЫН ДАВШИЛТ МОНГОЛ НҮҮРСИЙГ ШАХНА

ОХУ, Хятадын нүүрсний зах зээлд Монголтой ана мана, ач тач өрсөлдөх гээж байна



Г.Байгал
@baigalZGM

Азийн эрчим хүчний хэрэглээ огцом өсөж, нүүрсний эрэлт нэмэгдэх нь аль эртнээс тодорхой байв. Тиймээс газрын тос, байгалийн хий, нүүрс зэрэг эрчим хүчний нөөцөөрөө дэлхийд гайхуулдаг ОХУ-д Азийн зах зээлийг атгах амбиц энэ зууны эхнээс буцаж эхэллээ. Оросын алсын хараа, ашиг сонирхол Азийн орнуудыг чиглэх зуур олон жилийн турш эрчим хүчний салбарт ганзага нийлж байсан барууны зарим оронтой хойд хөрш түнжин хагарч, түншлэлд нь ан цав үүсэх болов.

АЗИД ЭРЭМБЭ АХИУЛАХ АМБИЦ

Европын орнуудад газрын тос, байгалийн хийгээ зарж, улсын төсвийнхөө багагүй хэсгийг бүрдүүлдэг байсан ОХУ геополитикийн харилцаанаас үүдэн гол худалдагч авагчдаа алдаж, барууны орнууд ч хойд хөршийн экспортын гол бүтээгдэхүүнүүдэд худалдааны хориг тавилаа. Яг үүнтэй зэрэгцэн хойд хөрш эрчим хүчний салбарт баримтлах бодлогоо эрс өөрчилж, “Эрчим хүчний стратеги-2030” хөтөлбөр баталсан байдаг. Бодлогын зураглалаар байгалийн хий, газрын тос, нүүрс зэрэг эрчим хүчний гол түүхий эдийн нийлүүлэлтээ Ази руу чиглүүлж, дэлхийн хамгийн өсөлттэй зах зээлээс ашиг хүртэхээр шийджээ.

Энэ амбицынх нь нэг хэсэг болсон нүүрсний салбарыг эрчтэй дэмжиж, экспортыг нь ирэх 20 жилд хоёр дахин өсгөн, 430 сая тоннд хүргэх зорилт тавьсан юм.



Бараг хагас тэрбум тоннд хүрэх нүүрсний нийлүүлэлтийг 82 ил, 64 далд уурхайгаас олборлохоор төлөвлөсөн.

Дэлхийн нүүрсний хамгийн том нийлүүлэгч болохын тулд ОХУ үйлдвэрлэлийн тулх цэгээ өөрчилж, олборлолтын сав газраа Алс Дорнод, Сибирийн нутаг дэвсгэрт шилжүүлсэн байна. Улмаар алс хязгаар энэ бүс нутгуудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, олон тооны орд уурхайн үүдийг нээж, хүчин чадлыг өргөтгөсөн. Далайн боомт болон төмөр замын хүчин чадлаа сайжруулан, шинэчлэх ажлуудыг ч ар араасаа хийжээ. Хойд хөрш нүүрсний салбарын үйлдвэрлэл болон дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дэмжихэд нийт 22.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө ч гаргасан байгаа юм.

БОЛОМЖ БҮРИЙГ АТГАСАН НЬ

Ингээд зорилгоо тодорхойлж, ажлаа эхлүүлсэн ОХУ зугуухан атлаа зогсолтгүй Азийн зах зээл рүү довтолж эхлэх нь тэр. Нүүрсний салбарын сүүлийн 3-4 жилийн нөхцөл байдлыг харвал хойд хөрш зогсолтгүй давшилж, нүүрсний зах зээлд бий болсон сул зай, боломж бүрийг алдалгүй атгасан нь харагдана.

Олон улсын харилцаанаас үүдэн 2017 онд БНХАУ Хойд Солонгосын нүүрсэнд экспортын хориг тавьсан. Энэ хоригоос хамгийн их хожож, урд хөршийг чиглэх нүүрсний нийлүүлэлтээ хамгийн эрчтэй хийгээд тогтмол тэлсэн тоглогч бол ОХУ. Хойд Солонгосын нүүрс хоригт хүлэгдсэн эхний гурван сард гэхэд Хятадыг чиглэх ОХУ-ын нүүрсний нийлүүлэлт бараг 40 хувиар өсөж

байжээ. Энэ өрсөлдөөнөөс нэг тоглогч ухрахад бусад нь орон зайг нь хэрхэн булааж болдгийг Умард Солонгос болон хойд хөршийн жишээнээс харж болно.

Ийнхүү олон улс, ялангуяа, урд хөршийн зах зээлд зогсолтгүй урагшилж буй ОХУ-ын экспорт 2018 онд сүүлийн таван жилийн дээд цэгт хүрчээ. Мөн нүүрсний олборлолт нь 433 сая тоннд хүрсэн нь олон жил харагдаагүй онцлох үзүүлэлт аж. Энэ мэт нүүрсний салбар дахь Оросын ялалтыг баталсан тоон үзүүлэлт, үр дүнгүүд хойд хөршийн хэвлэлүүдээр хөвөрч байна.

АВСТРАЛИЙН УХРАЛТ, ОХУ-ЫН ДАВШИЛТ

Одоогоор урд хөршийн зах зээлд коксжих нүүрсний нийлүүлэлтээр Австрали тэргүүлж, аман хүзүүнд нь Монгол Улс бичигдэж буй бол бидний араас ОХУ нэхэж яваа. Гэхдээ энэ оноос урд хөрш нүүрсний хамгийн том түншийнхээ нийлүүлэлтийг удаашруулж эхэлсэн. Зөвхөн Хятад гэлтгүй дэлхийн нүүрсний зах зээлд дэндүү том байр суурь эзэлдэг Австралийн тээвэрлэлт Хятадын зарим боомтод саатсан нь энэ зах зээлд чамлахааргүй өөрчлөлт дагуулж мэдэхээр байгаа.

Хэдийгээр хоёр улсын аль аль нь хурц мэдэгдэл хийлгүй өдий хүрч буй ч өмнөд хөршийн хэд хэдэн боомтод Австралийн нүүрсийг хяналт шалгалт нэрийн дор хязгаарласан нь үнэн. Цаашид ч энэ тодорхойгүй байдал хэрхэн үргэлжлэх нь асуулт хэвээр байна. Ингэснээр дэлхийн нүүрсний хамгийн том хэрэглэгч БНХАУ-ын зах зээлийн дархан аварга болох Австралийн нийлүүлэлт саарахаар байна. Харин үүнийг нь хэн нөхөх вэ.

Уг нь Австралийн араас бичигдэх Монгол Улсад нийлүүлэлтээ ахиулах боломж хамгийн түрүүнд бий болмоор. Гэтэл энэ өрсөлдөөнд аль эртнээс бэлтгэсэн ОХУ биднийг түрүүлж гүйцээд, боломжийг ашиглах

нь. Хятадын зарим боомтоор нэвтрэх Австралийн нүүрс хязгаарлалттай нүүрс тулсан энэ оны эхний гурван сарын байдлаар Австралийн орон зайг хамгийн идэвхтэй ашиглаж буй орны тоонд Орос улс бичигдэж байна.

Орос үнэндээ өнгөрсөн жилүүдэд гэрийн даалгавраа маш сайн хийсэн. Тойм тооцоогоор нүүрсний нөөц нэг их наяд тонныг давсан Орос улс бидэн шиг ганцхан Хятадад нүүрс борлуулдаггүй. Япон, БНСУ, Турк, АНУ зэрэг 80 улсад нийлүүлэлт хийж орлого олдог. Энэ улс сүүлийн жилүүдэд нэмүү өртөг шингээгүй түүхий нүүрсээ хилийн чанадад хямаар зарах бус угааж, боловсруулан ахуу ханшаар борлуулах болсон. Ийм үйлдвэрийг олноор байгуулж, боловсруулсан нүүрсний хэмжээгээ 2017 онд гурван хувиар өсгөж, 195 сая тоннд хүргээд байна. Мөн дэлхийн нүүрсний салбарын гол үзүүлэлт болсон хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, 2000 оноос гурав дахин өсгөжээ.

Ийм хүчтэй, амбицтай, аль эртнээс өөрийгөө өрсөлдөөнд сойсон, олон улсын тавцанд нэр нөлөөтэй ОХУ, Хятадын нүүрсний зах зээлд Монголтой ана мана, ач тач өрсөлдөх гэж байна. Ирэх жилүүдэд манай экспортын гол түшиц болсон Хятадын нүүрсний зах зээлд ОХУ хэмээх хүчтэй тоглогчийн байр суурь улам нэмэгдэнэ. Гэтэл энэ өрсөлдөөнийг урьдчилан таамаглаж, анхаарч үзэх сөхөө ч үгүй тэнгэрийн тоогоо ярьсаар сууна.

Зам дэд бүтцээ сайжруулж, салбарын олборлогчдоо дэмжин, зах зээлийн ширүүн өрсөлдөөнд бэлтгэх бус харин ч төмөр замаа гацааж, төр, хувийн хэвшил хоёр нуруу нуруугаа харуулсаар. Гэтэл амбиц тээсэн хойд хөрш бидний энэ арчаагүй байдлыг өршөөж энэрэнгүй хандах нь юу л бол. Зах зээл дэх бусдын орон зайг булааж ирсэн зангаараа Монголын бүх боломжийг жахлахгүй залгихч болов уу. [ЗГМ]



ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

